# БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

*Баталгаажуулсан:* ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

20.... оны .... сарын ....-ны өдөр

*Нэгтгэж тайлагнасан,*
*хяналт-шинжилгээ, үнэлгээ*
*хийсэн:* ***Нэгжийн дарга***

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

20.... оны .... сарын ....-ны өдөр

*Нэгтгэн боловсруулсан:* ***Албан хаагч***

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

20.... оны .... сарын ....-ны өдөр

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

(Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээгээр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, загварын дагуу боловсруулан тайлагнаж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 үндсэн, 3 нийтлэг чиг үүргийн хүрээнд дэвшүүлсэн нийт 17 гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх **83 арга хэмжээний** хэрэгжилтийг тайлагнав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 83 арга хэмжээ тус бүр болон гүйцэтгэлийн зорилтын үр дүнгийн үзүүлэлт тус бүрээр тайлагнасан болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн дүнгээс дүгнэхэд, 2020 онд төлөвлөсөн нийт 17 зорилт, 83 арга хэмжээний хэрэгжилт дунджаар **90.7 хувийн** гүйцэтгэлтэй байна. Улс орны хэмжээнд үүссэн Коронавирусын халдвар (Ковид 19)-ын нөхцөл байдлаас үүдэлтэй гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжиж, хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой зарим төлөвлөсөн ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сөрөгөөр нөлөөлсөн.

Хэрэгжилтийн дүнг тооцохдоо Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалыг баримтлан дүгнэсэн болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дүнгийн товчоо

| Д/д | Хэрэгжилтийн үнэлгээний хувь | Заалт (арга хэмжээ)-ын тоо |
|---|---|---|
| 1 | **Нийт арга хэмжээ** | **83** |
| 2 | Үүнээс: 100 % | 56 |
| 3 | 90 % | 15 |
| 4 | 70 % | 5 |
| 5 | 50 % | 1 |
| 6 | 30 % | 6 |
| 7 | 0 % | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь буюу дундаж үнэлгээ - 90.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.** | | |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнгээр 30-70 хувийн үнэлгээ бүхий нийт 12 арга хэмжээ байна. Эдгээр арга хэмжээний жагсаалтыг энэхүү тайлангийн “Хавсралт” хэсэгт хавсаргав.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан эдгээр зорилт, арга хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны батлагдсан 1,254.7 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн болно.

---------- oOo ----------

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Үндсэн чиг үүрэг №1.<br>Төрийн өмчийн удирдлага, зохицуулалт | 2 | 8 | 68.75 % |
| 2. | Үндсэн чиг үүрэг №2.<br>Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт | 2 | 5 | 94.0 % |
| 3. | Үндсэн чиг үүрэг №3.<br>Төрийн өмчийн хяналт шалгалт | 1 | 3 | 100.0 % |
| **Нийт** | | **5** | **16** | **87.6 %** |

# НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 1.1.** Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

**Төлөвлөлтийн уялдаа:** Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн зорилт 11, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ 5.2.1.2, Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэл.

<table>
<tr><th>№ 01(1)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1-р арга хэмжээ.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн зорилт 11, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2, Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэл.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">.... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">- Хууль, эрх зүйн хэлтэс (Цаашид “ХЭЗХ” гэх);<br>- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Цаашид “ТӨУЗХ” гэх);<br>- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Цаашид “ТӨБАХ” гэх);<br>- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Цаашид “ТӨХШХ” гэх);<br>- Захиргаа, удирдлагын хэлтэс (Цаашид “ЗУХ” гэх).</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт өнөөгийн нийгмийн харилцаанд нийцэхгүй болсон, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй, бусад хууль болон зарим зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилтэй.<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаарх журам, заавpыг шинэчлэх шаардлага бий болсон;<br>- Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх шаардлага үүссэн.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн эцэслэн боловсруулсан эсэх;<br>- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон бусад хууль тогтоомж, шаардлагад нийцүүлсэн эсэх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгаа, тооцоог хийх;<br>- Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үе шатны ажлыг хэрэгжүүлсэн байх;<br>- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх;<br>- Төрөөс төрийн өмчийн талаар болон өмч хувьчлал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого тодорхой болсон байх;<br>- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын болон олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн байх.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нар томилогдон ажиллаж байна. Ажлын хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үр дагаварт үнэлгээ хийхээс гадна БНСУ, Казкастан, Эстон зэрэг бусад орны хуулийг судалж үзсэний үндсэн дээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд уг үзэл баримтлалд</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | санал авахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2165 тоот албан бичгээр хүргүүлээд байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “төрийн нийтийн өмч”-ийг Үндсэн хуулийн 6.2-т нийцүүлэн тодорхойлж, өмчлөгч нь бүх ард түмнийг төлөөлж УИХ байх зохицуулалтыг оруулна гэж хуулийн үзэл баримтлалд тусгасан болно.<br>УИХ-ын Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад эдгээр хуулиудыг хэлэлцэхээр төлөвлөгдсөн. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас улс орон даяар гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал зарлаж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор ажлын хэсэг цуглаж хуралдах боломжгүй байгаа ч онлайн хэлбэрээр хуралдаж, хуулийн төслийн 1-3 дугаар бүлгийг бичиж эхэлсэн. Хуулийн төслийг намрын чуулган тарахаас өмнө өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | Тусгайлан хөрөнгө зарцуулаагүй. |
| | *Хүрсэн түвшин* | Үзэл баримтлалыг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хуулийн төслийг бичиж эхэлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, нээлттэй байдлыг ханган, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан. Холбоос: [https://www.pcsp.gov.mn/n/1273](https://www.pcsp.gov.mn/n/1273) . |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 30 хувь |

<table>
<tr><th>№ 02 (2)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2-р арга хэмжээ<br>Төрийн өмчийг 2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт боловсруулах, батлуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Стратегийн зорилтын 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.3, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэл.</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">-</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Холбогдох судалгаа, тооцоолол хийсэн байх;<br>- Үндсэн чиглэл, жагсаалтын төслийг боловсруулсан байх;<br>- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулсан байх;<br>- Холбогдох хууль тогтоомж, журамд нийцсэн байх.</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Судалгаа бүрэн хийгдэж дууссан байна;<br>- Үндсэн чиглэлийн үзэл баримтлалыг боловсруулсан байна;<br>- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан байна;<br>- Үндсэн чиглэлийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдсэн байна;<br>- Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийгдсэн байна;<br>- Хувьчлалаас олох орлогын төсөөлөл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийгдсэн байна.<br>Жилийн эцэст:<br>- Холбогдох яамдаас санал авч нэгтгэсэн байна;<br>- Үндсэн чиглэл, жагсаалтын төслийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна;<br>- Засгийн газарт хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргасан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэл хийгдэх хүртэл тодорхой чиглэл боловсруулах боломжгүй.<br>Хуулийн төсөлд Үндсэн чиглэлийг Засгийн газраас батлуулах тухай зохицуулалт тусгагдсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">-</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Үндсэн чиглэл боловсруулахын тулд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн судалгааг гарган дүгнэлт, саналыг бэлтгэж байна. Хуулийн шинэчлэл хийгдэх хүртэл тодорхой үр дүн гарах боломжгүй байна.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | 30 хувь |

| *№ 03 (3)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.3-р арга хэмжээ.** Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ..... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ, ХЭЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан журам үйлчилж байгаа, журмыг шинэчлэн боловсруулах шаардлага бий болсон. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Журмын төслийг боловсруулсан эсэх;<br>- Холбогдох хууль, журамд нийцүүлсэн эсэх;<br>- Батлуулах арга хэмжээ авсан эсэх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | ***Эхний хагас жилд:***<br>- Журмын хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлсон байна;<br>- Журмын төслийг боловсруулж, холбогдох хэлтэс, алба, хэрэглэгчийн санал авсан байна;<br>- Журмын төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдсэн байна;<br>- Төслийг эцэслэн боловсруулсан байна. | | | | |
| | | ***Жилийн эцэст:***<br>- Журмын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ”)-ын хуралдаанд танилцуулж, Засгийн газарт хүргүүлсэн байна;<br>- Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин боловсронгуй болсон байна;<br>- Журмыг мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн хүрээнд дахин боловсруулсан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлах тухай зохицуулалтыг тусгасан. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | - | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэл хийгдэх хүртэл үр дүн нь хүлээгдэж байгаа. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 70 хувь - | | | | |

| *№ 04 (4)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4-р арга хэмжээ.** “Төрийн өмчийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах, батлуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2, 5.2.1.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ..... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨБАХ, ХЭЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэхэд мөрдүүлж байгаа;<br>- ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар тэмдэглэлээр 2019 оны 400 дугаар тогтоол өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байх;<br>- Холбогдох хууль, журамд нийцүүлсэн эсэх; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - Батлуулах арга хэмжээ авсан эсэх. |
| | *Хүрэх түвшин* | ***Эхний хагас жилд:***<br>- Зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлсон байна;<br>- Тогтоол шийдвэр, журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, холбогдох хэлтэс, албаны санал авсан байна. |
| | | ***Жилийн эцэст:***<br>- Журам шинэчлэх асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна;<br>- Батлагдсан тогтоол шийдвэр, журмыг мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна;<br>- “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулах эрх зүйн акт боловсронгуй болсон байх:<br>- Эрх зүйн актын хэрэгжилтэд хяналтад тавьсан байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг шинэчлэх хүрээнд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ыг тус тус шинэчлэн боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, уг маягт, аргачлалыг 715 дугаар тогтоолоор батлуулан мөрдүүлж байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | ТӨБЗГ-ын 2020 оны 715 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ыг батлуулав. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 05 (5)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.5-р арга хэмжээ.**<br>Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх зохицуулалттай холбоотой хууль, эрх зүйг боловсронгуй болгох асуудлаар төсөл боловсруулах, батлуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2, 5.2.1.4, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ..... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨБАХ, ХЭЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлэх, зарим зохицуулалтыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэх, боловсронгуй болгох шаардлага бий болсон. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх зохицуулалтад оруулах өөрчлөлтийг тодорхойсон байх;<br>- Холбогдох хууль, журамд нийцүүлсэн эсэх;<br>- Батлуулах арга хэмжээ авсан эсэх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | ***Эхний хагас жилд:***<br>- Зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлсон байна;<br>- Тогтоол шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох хэлтэс, алба, хэрэглэгчийн санал авсан байна;<br>- Төслийг эцэслэн боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | | | | |
| | | ***Жилийн эцэст:***<br>- Батлагдсан тогтоол шийдвэрийг мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна;<br>- Эрх зүйн актын хэрэгжилтэд хяналтад тавьсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах үүднээс зарим зохицуулалтыг тодорхой болгох асуудлаар тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар хуралдаанд хэлэлцүүлж батлуулсан. Хэлэлцсэн асуудлаар дараах шийдвэр гарсан:<br><br>- “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тогтоол; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоол;<br>- “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай” 51 дүгээр тогтоол. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | ТӨБЗГ-ын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн зохицуулалтыг мөрдүүлэх арга хэмжээ авч, түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, түрээслэгчийг сонгон шалгаруулж байгаа байдал, түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх асуудалд хяналт тавин ажиллав. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 1.1.-ийн үр дүн:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон бусад хууль тогтоомжид нийцүүлж, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.1.1.** Боловсруулах хууль тогтоомжийн төсөл | тоо | 1 | 2 | - | 2 | 1 (Хуулийн төслийн үзэл баримтлал) |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.1.2.** Боловсруулах журам, заавар | тоо | 8 (ТӨУЗХ-3, ТӨБАХ-5) | 1 (ТӨБАХ-1) | 3 (ТӨБАХ-3) | 3 (ТӨУЗХ-1, ТӨБАХ-2) | 5 (ТӨУЗХ-1, (ТӨБАХ-4) |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.1.3.** Батлагдсан, мөрдүүлсэн байх журам, заавар | тоо | 6 (ТӨУЗХ-2, ТӨБАХ-4) | 1 (ТӨБАХ-1) | 3 (ТӨБАХ-3) | 3 (ТӨУЗХ-1, ТӨБАХ-2) | 4 (ТӨУЗХ-0, ТӨБАХ-4) |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨУЗХ, ТӨБАХ, ХЭЗХ

**Гүйцэтгэлийн зорилт № 1.2.** Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, удирдлагын оновчтой хэлбэрийг хэрэгжүүлж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх

**Төлөвлөлтийн уялдаа:** Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ 5.2.1.1, 5.2.1.2.

| *№ 06 (6)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1-р арга хэмжээ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.1, 5.2.1.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ..... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани – 51;<br>- Төлөөлөн удирдах зөвлөл – 39;<br>- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн – 336, үүний 107 нь хараат бус гишүүн, 229 нь төрийн төлөөлөл;<br>- 2019 онд 216 асуудлаар 51 компанийн 39 ТУЗ-д 100 удирдамж өгсөн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - ТУЗ-д өгсөн удирдамжийн тоо;<br>- ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдэд өгсөн удирдамжийн тоо;<br>- Удирдамжийн хэрэгжилт, хувиар. | | | | |
| | *Хүрэх түвшин* | ***Эхний хагас жилд:***<br>- 26 компанийн 14 ТУЗ-д 228 асуудлаар 76 удирдамж өгсөн байна;<br>- 50 компанийн 36 ТУЗ-д 660 асуудлыг хэлэлцэхэд төрийн өмчийн төлөөлөл | | | | |

| | | |
|---|---|---|
| | | хэрэгжүүлсэн байна;<br>- Удирдамжийн хэрэгжилт – 100 хувь байна. |
| | | ***Жилийн эцэст:***<br>- 26 компанийн 14 ТУЗ-д 456 асуудлаар 152 удирдамж өгсөн байна;<br>- 50 компанийн 36 ТУЗ-д 1320 асуудлыг хэлэлцэхэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлсэн байна;<br>- Удирдамжийн хэрэгжилт – 100 хувь байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 компанийн 39 төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгч, УУХҮЯам, ЭХЯам болон ЗТХЯамнаас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй компаниудын ТУЗ-д чиглэл өгч ажиллав. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд нийт 347 хүн гишүүнээр ажиллаж байгаагаас 236 гишүүн нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид байгаа бөгөөд 111 нь хараат бус гишүүд байна. Үүнээс 70 гаруй нь (давхардсан тоогоор) Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид байна.<br>Төрийн өмчийн удирдлага, төлөөллийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал болон Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, түүний гүйцэтгэх удирдлагад албан даалгавар, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | - |
| | *Хүрсэн түвшин* | 2020 онд 51 компанийн 39 ТУЗ-д удирдамж өгсөн.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 компани, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ-ны хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлж буй компаниуд болон 21 ТӨҮГ-т төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлсэн. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь |

| *№ 07 (7)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.2-р арга хэмжээ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэгтгэлийг гаргаж, дүн шинжилгээ хийж, нэгдсэн мэдээллийг боловсруулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.1. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | .... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг жил бүр нэгтгэж, албан хэрэгцээнд зориулан 2016, 2017, 2018 товхимлыг хэвлүүлж, харьцуулан судлах, бодлого, төлөвлөлтийг оновчтой хийхэд шаардлагатай суурь судалгаа бий болсон. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - 2019 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэж, дүн шинжилгээ хийж танилцуулсан байна. | | | | |
| | *Хүрэх түвшин* | ***Эхний хагас жилд:***<br>- Санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн дүн мэдээг хуулийн этгээд бүрээр цуглуулж нэгтгэсэн байна;<br>- Дүн шинжилгээ хийж, нэгдсэн танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн байна;<br>- Албан хэрэгцээнд зориулж товхимол бэлтгэж хэвлүүлнэ. | | | | |
| | | ***Жилийн эцэст:***<br>- Товхимлыг холбогдох алба хаагчид, хэрэглэгчид хүргэж, мэдээллийг түгээн сурталчилсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлж буй 21 ТӨҮГ, 46 ТӨХК, 4 ТӨХХК, 2 ТӨОК, нийт 73 хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг урьдчилсан байдлаар нэгтгэж, танилцуулга, дүгнэлт, мэдээллийг бэлтгэн удирдлагын түвшинд болон ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 93 хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, мэдээллийг нэгтгэн тусгасан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт" товхимлыг 100 ширхэг хэвлүүлэн, ЗГХЭГ болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн мэдээллийг сурталчилсан. | | | | |

| | | |
|---|---|---|
| | *Зарцуулсан хөрөнгө* | - |
| | *Хүрсэн түвшин* | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээд нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 32 их наяд 426 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшин 43990 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, 9 их наяд 693 тэрбум төгрөгийн орлого олж, 1 их наяд 594.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үр дүнтэй байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 08 (8)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.3-р арга хэмжээ<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2020” нэлттэй өдөрлөг зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2.</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах шаардлагатай;<br>- 2017, 2018, 2019 онд нэлттэй өдөрлөг зохион байгуулсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Хөтөлбөр, зохион байгуулалт, зардлын төлөвлөлт хийсэн эсэх;<br>- Нэлттэй өдөрлөг зохион байгуулсан эсэх;<br>- Олон нийтийн хамрагдалтын тоо;<br>- Үйл ажиллагаагаа сурталчилж оролцсон хуулийн этгээдийн тоо.</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Нэлттэй өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан байна;<br>- Хөтөлбөр, төлөвлөгөө (удирдамж) батлагдсан байна;<br>- Шаардлагатай зардлын тооцоог хийж, төсвийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.<br><br>Жилийн эцэст:<br>- Нэлттэй өдөрлөгийн үйл ажиллагаанд 2500< иргэд, олон нийтийн төлөөлөл оролцож, мэдээлэл авсан байна;<br>- Нэлттэй өдөрлөгт 70< компани, үйлдвэрийн газар оролцож, иргэд, олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа хүргэсэн байна;<br>- “Төрийн өмчийн менежмент, нийгмийн хариуцлага – 2020” нэлттэй өдөрлөгийн үр дүнг жилийн эцсийн тайланд тусгасан байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах нэлтэй өдөрлөгийг 2020 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">-</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2020” нэлттэй өдөрлөгийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Буянт ухаа спортын ордонд зохион байгуулахаар төлөвлөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/68 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд “Чиглэл хүргүүлэх тухай”, нийт 21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт “Хамтран ажиллах тухай” 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А-1/1935 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Өдөрлөгт оролцох 105 хуулийн этгээдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан холбогдох чиглэл зааврыг өгч ажилласан.<br>Коронавирусын халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотойгоор зохион байгуулагдах боломжгүй болсон.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">30 хувь</td></tr>
</table>

**Гүйцэтгэлийн зорилт № 1.2.-ийн үр дүн:** Төрийн өмчийн удирдлага, менежмент, компанийн засаглалын үр нөлөө дээшилсэн байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.1.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаанд тавьсан хяналтын үйл ажиллагаа | Тоо | 2 | 1 | 1 | 2 | 2 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.2.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өгсөн зөвлөмж, чиглэл, албан даалгавар, түүний хэрэгжилт | Тоо, хувь | 3, 97.0 | 3, 100 | 3 | 5, 100 | 5 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.3.** Ашигтай ажилласан төрийн өмчит компани, үйлдвэрийн газар | тоо | 52 | 52 | - | 52 | 46 (Цар тахлаас үүдэн зарим компанийн үйл ажиллагаа бүрэн болон хэсэгчлэн зогссонтой холбоотой ашигтай компанийн тоо цөөрсөн) |
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.4.** Алдагдалтай ажилласан төрийн өмчит компани, үйлдвэрийн газар | тоо | 21 | 21 | - | 21 | 27 |
| 5. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.5.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт цэвэр ашиг, алдагдал | Тэрбум төгрөг | 1,614.8 ... | 1,346.8 ... | | 1,781.8 ... | 688.2 (2019 оны гүйцэтгэлээс 926.6 тэрбум төгрөгөөр бага байгаа боловч 2020 оны төлөвлөснөөс 49.1 тэрбум төгрөгөөр ашиг нэмэгдсэн байна. Баланс гарах үед өсөх магадлалтай) |
| 6. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.6.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цэвэр ашгийн өсөлт, бууралт | хувь | 20 | - | | 10 | 2020 оны төлөвлөгөө-нөөс 7.6 %-ийн өсөлттэй. 2019 оны түвшнээс 57.3 %-ийн бууралттай байна. |
| 7. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.7.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн алдагдлын өсөлт, бууралт | хувь | 20 | - | - | 10 | (Цар тахлаас үүдэн ЭХ-ний салбарын компанийн алдагдал 75.1 тэрбум, компанийн үйл ажиллагаа бүрэн болон хэсэгчлэн зогссонтой холбоотой МИАТ ТӨХК-30.0 тэрбум, АТҮТ ТӨҮГ 2.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.8.** Төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 100 | 100 | 35.6 | 100 | 98.0 |
| 9. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.2.9.** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох заалтын хэрэгжилт (3 заалт хамаарна) | хувь | 100 | 100 | - | 100 | 70.0 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨУЗХ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 1.3.** Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, хариуцлагыОг сайжруулна.

**Төлөвлөлтийн уялдаа:** Стратегийн зорилт 2.4.2, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ 1.4, 5.2.1, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 4.1.3.1.2.

<table>
<tr><th>№ 9 (9)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.1-р арга хэмжээ<br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах ажлын бэлтгэл хангах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 70 дугаар зүйлийн 70.4 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.2, ЗГҮАХХАХТ-ний арга хэмжээ 1.4.5, Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨБАХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистик мэдээллийн маягтуудыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн тушаалаар баталсан;<br>- 2016 онд эдгээр маягтыг ашиглан улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж байсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Тооллого явуулах Засгийн газрын шийдвэрийн гаргуулсан байх;<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистик мэдээллийн маягтуудад холбогдох өөрчлөлт оруулах асуудлаар Үндэсний статистикийн хорооны зөвшөөрөл авсан байх;<br>- Тооллогод ашиглах маягтуудыг баталсан байх;<br>- Тооллогын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулсан байх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого явуулах Засгийн газрын шийдвэрийг гарсан байна;<br>- Үзлэг, тооллогод ашиглах маягтуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Үндэсний статистикийн хорооны зөвшөөрөл авсан байна;</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн болон тооллогод ашиглах маягтуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна;<br>- Улсын үзлэг, тооллогын ажилд зарцуулах зардлын төсвийн тооцоог хийж, төслийг бэлтгэсэн байна;<br>- Тооллогын ажлын төлөвлөгөөг боловсруулсан байна.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2020 оны 9 дүгээр тогтоолоор батлуулсан. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх нөхцөл байдлын улмаас үзлэг тооллогын ажлыг хойшлуулж, 2021 онд зохион байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулан 2020 оны 08 сарын 12-ны өдрийн 46 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв:<br>- ҮСХ-ны даргын 2020 оны А/33 дугаар тушаалаар Төрийн өмчийн бүртгэлийн</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | ТӨХ 1-11, захиргааны статистикийн ТӨ 1-ТӨ 13.2 гэсэн нийт 29 маягтыг нөхөх заавар, кодын хамт батлан мөрдүүлэх зөвшөөрөл гаргуулсан;<br>- ҮСХ-ны зөвшөөрлийг үндэслэн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистик мэдээллийн болон төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтуудад өөрчлөлт оруулж, төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх, улсын үзлэг, тооллого явуулахад ашиглах ТӨХ-1-ээс ТӨХ-11, ТӨ-1ээс ТӨ-15, нийт 29 маягтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолоор батлуулсан;<br>- Тооллогыг цаг үеийн нөхцөл байдлаас болоод 2021 онд зохион байгуулахаар холбогдох газруудад мэдэгдэж, чиглэл өгсөн.<br>- Засгийн газрын 2020 оны 9, 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын зардлыг 2021 оны төсөвтөө тусгуулж, бэлтгэл ханган ажиллах талаар нийслэл, 21 аймгийн Засаг дарга, орон нутгийн өмчийн байгууллагад “Тооллогын бэлтгэл ажил хангах тухай” албан бичиг хүргүүлж, чиглэл өгсөн;<br>- Орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, батлагдсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ТӨБЗГ-т хүргүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт Засгийн газрын тогтоол шийдвэрээр даалгасантай холбогдуулж 2021 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган аймгийн Газар зохион байгуулалт, барилга, хот байгуулалтын газар, хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагатай уялдаатай ажиллах, улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах асуудлаар зөвлөмж боловсруулан аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн;<br>- Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж, албан даалгавар хүргүүлэх тухай төрийн байгууллага албан газар, төсвийн байгууллага, төрийн (орон нутгийн) өмчит болон төрийн (орон нутгийн) өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд албан бичгээр хүргүүлсэн. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | - Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого явуулах Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор шийдвэр гаргуулсан, уг шийдвэрт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоолоор үзлэг тооллогыг 2021 онд зохион байгуулахаар хойшлуулсан;<br>- Үзлэг, тооллогод ашиглах маягтуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Үндэсний статистикийн хорооноос батлах зөвшөөрөл авсан;<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн болон улсын үзлэг тооллогод ашиглах маягтуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2020 оны 323 дугаар тогтоолоор батлуулсан;<br>- Улсын үзлэг, тооллогын ажилд зарцуулах зардлын төсвийн тооцоог хийж, төслийг бэлтгэсэн;<br>- 2021 онд зохион байгуулах улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөг боловсруулан холбогдох газруудад албан бичгээр хүргүүлсэн. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 10 (10)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.2-р арга хэмжээ**<br>Аймаг, нийслэл, орон нутаг дахь төрийн өмчит хуулийн этгээдэд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.2, ЗГҮАХХАХТ-ний арга хэмжээ 5.2.1.4, АТҮХХАХТ-ний арга хэмжээ 4.1.3.1.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨБАХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд төрийн өмчит 967 хуулийн этгээдийн “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны хэрэгжилтийг дүгнэж, гэрээг шинэчлэн байгуулсан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Холбогдох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байх;<br>- Төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан 2019 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний загвар болон үнэлгээний хуудсыг шинэчлэн батлуулсан байх;<br>- Гэрээг дүгнэж, үнэлгээг баталгаажуулсан байх (хуулийн этгээдийн тоогоор);<br>- ТӨБЗГ-ын хуралдаанд нэгдсэн дүнг танилцуулсан эсэх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Холбогдох журмыг шинэчлэн боловсруулах ажил хийгдсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Шинэчлэн боловсруулсан журмыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулсан байна; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх, гэрээ байгуулах ажилд цахим системийг ашиглах боломжийг судлах;<br>- “Өмч эзэмшүүлэх гэрээ”-ний дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан байна;<br>- Төрийн өмчит 800 хуулийн этгээдийн “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулж хүргүүлсэн байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны биелэлтийг цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан цахим хэлбэрээр дүгнэв. 2020 онд төрийн өмчит 961 хуулийн этгээд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнүүлснээс 182 хуулийн этгээд “сайн”, 779 хуулийн этгээд “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.<br><br>“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнэхдээ холбогдох журмын дагуу 5 үндсэн үзүүлэлтээр байгууллага тус бүрийг дүгнэсэн бөгөөд улсын дундаж үнэлгээ “хангалттай” буюу 94.1 хувьтай, өнгөрсөн оны дүнгээс 2.1 хувиар өссөн дүнтэй байна.<br><br>“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 597 дугаар тогтоол гаргасан бөгөөд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авах талаар зөвлөмж боловсруулан төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэхээр бэлтгэж байна. Түүнчлэн төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эзэмших, ашиглах газрыг баталгаажуулах, үнэлэх ажлыг бүрэн хийж дуусгах, тэг үлдэгдэлтэй буюу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэлгээ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох зэрэг ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчил, дутагдал гарч байгааг 2021 онд зохион байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын бэлтгэл хангах ажлын хүрээнд шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөж байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийн улсын дундаж үнэлгээ “хангалттай” буюу 94.1 хувьтай, өнгөрсөн оны дүнгээс 2.1 хувиар өссөн дүнтэй байна.<br><br>Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлж, “Үлгэр жишээ” дүгнүүлсэн төрийн өмчит 27 хуулийн этгээд, 31 нягтлан бодогчийг шагнаж урамшуулсан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 1.3.-ын үр дүн:** Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын бэлтгэл хангагдаж, төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтын үр дүнд ахиц гаран хариуцлага дээшилсэн байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.3.1.**<br>Тооллого явуулах асуудлаар Засгийн газрын шийдвэр гарсан эсэх | шийдвэр | - | Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулгыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | | Засгийн газрын шийдвэр гарсан байна. | Засгийн газрын 2020 оны 09, 46 дугаар тогтоол гарсан. |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 1.3.2.**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистик мэдээллийн маягтуудад холбогдох өөрчлөлтийг хийж, батлуулсан байна. | шийдвэр | - | Үндэсний статистикийн хорооны даргын тушаал гарсан байна. | Үндэсний статистикийн хорооны 2020 оны А/33 дугаар тушаалаар маягт батлах зөвшөөрөл олгосон. | Маягтууд батлагдсан байна. | Үндэсний статистикийн хорооны 2020 оны А/33 дугаар тушаалаар маягт батлах зөвшөөрөл олгосон. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.1.8.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт өр төлбөр, өсөлт, бууралт | хувь | 10-20 | ... | | 20 | 1.2%-ийн бууралттай |
| 9. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.1.9.** Гүйцэтгэх удирдлагын контрактыг “Сайн” болон “Хангалттай” дүнтэй дүгнүүлсэн захирлын тоо, нийт захирлын тоонд эзлэх хувь | Тоо,<br>хувь | 41<br>91.0 | 45<br>100 | 69<br>95.8 | 45<br>100 | 69<br>95.8 |
| 10 | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.1.10.** Компанийн засаглалын чиглэлээр хамтран ажилласан мэргэжлийн байгууллага | тоо | 2 | 2< | 2 | 2< | 3 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨУЗХ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.2.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлчилгээний ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Иргэн, аж ахуйн нэгж, мэргэжилтэй ажилтанд чиглэсэн үйлчилгээ

| *№ 05 (21)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1-р арга хэмжээ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн ил тод байдлыг хангуулах арга хэмжээ авч, хяналт тавих | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.4, 6.7-6.10 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, ЗГҮАХХАХТ-ний 5.2.1.2, АТҮХХАХТ-ний 4.1.3.1.3 дахь зорилт, арга хэмжээ, Засгийн газрын хуралдааны 2016 оны 52 дугаар тэмдэглэлийн XIII.3.4 дэх заалтаар төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байгаа байдалд тавих дотоод хяналт шалгалтыг сайжруулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад даалгасан. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 75 хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 95%-ийн гүйцэтгэлтэй байсан. | | | | |

| | | |
|---|---|---|
| | *Шалгуур үзүүлэлт* | - Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хувиар. |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байх;<br>- Хуулийн хэрэгжилт - дунджаар 70 хувь. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 95 хувь байх бөгөөд хэрэгжилт тогтмолжсон байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр албан даалгавар хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | - |
| | *Хүрсэн түвшин* | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор бүх компани, үйлдвэрийн газрууд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулсан, ихэнх тендер цахимаар явагдаж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай, 90 хувьтай байна. 2020 оны санхүүгийн тайлан балансын дүн аудитаар баталгаажиж, зөвлөмж гарсны дараа эцсийн үнэлгээ гарах болно. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь |

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) нарт) чиглэсэн үйлчилгээ

| *№ 06 (22)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2-р арга хэмжээ**<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг харьяа хуулийн этгээдэд хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавих | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, НАНБХАСЗАСЗУСТХуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ, ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд:<br>- Зөвлөмж чиглэл өгсөн тоо – 2 (албан бичгээр);<br>- Зөвлөмж чиглэлийн биелэлт 91.0 хувийн гүйцэтгэлтэй;<br>- Орхон аймаг дахь 2 хуулийн этгээдэд шалган туслах ажлыг гүйцэтгэсэн;<br>- Давхардсан тоогоор 58 ЭБАТ, нийт тоогоор 345 албан хаагчид зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өгсөн чиглэл, зөвлөмжийн тоо;<br>- Зөвлөмжийн хэрэгжилт, хувиар;<br>- Харьяа хуулийн этгээдийн ЭБАТ-ны үйл ажиллагааг шалгах, заавар, зөвлөмж, арга зүйгээр хангасан байдал, тоогоор. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хуулийн этгээдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, чиглэл өгөгдсөн байх;<br>- Зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтэд 2 дугаар улиралд хяналт тавьсан байх;<br>- Харьяа 3-5 хуулийн этгээдийн авлигын эсрэг үйл ажиллагаатай танилцаж, ЭБАТ-ны үйл ажиллагааг шалган зааварчилж, зөвлөмж, арга зүйгээр хангах. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Зөвлөмж, чиглэлийн биелэлтийг нэгтгэн дүгнэсэн байх, 4 дүгээр улиралд;<br>- Зөвлөмжийн биелэлт дунджаар 90-100 хувь байх. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | ЗГХЭГ болон АТГ-аас ирүүлсэн авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зөвлөмж, чиглэлийг харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, олон нийтэд сурталчлан таниулж, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч ажиллав. Тухайлбал, байгууллагын цахим системд холбогдох зөвлөмжүүдийг байршуулан мэдээлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт Авлигатай тэмцэх | | | | |

| | | |
|---|---|---|
| | | газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А-1/287 дугаартай албан бичгээр албан даалгавар хүргүүлсэн.<br>Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/13472 дугаартай албан бичгээр ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангах тухай өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, холбогдох эрх бүхий албан хаагчдад чиглэл, зөвлөмж өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.<br>Түүнчлэн, Орон нутгийн өмчийн газар болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудад Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх агуулгын хүрээнд ТӨУЗХ-ээс зөвлөмж, чиглэл өгч ажиллав. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Авлигын эсрэг хууль торгтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлага, чиглэлээр хангаж ажилласан. Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмж, чиглэлийн хэрэгжилт дунджаар 91.8 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 49 захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 41 ажилтан (ЭБАТ)-ыг зөвлөгөө, дэмжлэг, мэргэжил, арга зүйн удирдлагаар тухай бүр ханган ажилласан байна. 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр АТГ-аас зохион байгуулсан "Ярилцах цаг" уулзалтад 25 ЭБАТ, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад 41 ЭБАТ-ыг тус тус хамруулан авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулав.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн 1 захиралд авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил гаргасан нь тогтоогдсонтой холбоотой АТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох Төлөөлөн удирдах зөвлөлд хариуцлага тооцуулах талаар удирдамж өгч, хэрэгжилтийг хангуулав. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 2.2.-ын үр дүн:** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны ил тод байдалд ахиц гарч, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.1.**<br>Төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | хувь | 95.0 | 95.0 | 70.0 | 95.0 | 90.0 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.2.**<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өгсөн зөвлөмж, чиглэл | Тоо,<br>хэрэгжилтийн хувь | 2,<br>91.0 | 2,<br>80.0 | 2,<br>50.0 | 3,<br>91.0 | 3,<br>90.0 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.3.**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-д өгсөн мэргэжил, арга зүйн сургалт, зөвлөгөө, дэмжлэг | Тоо/удаа,<br>Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор) | 3,<br>58 | 1,<br>50 | 2,<br>66 | 2,<br>60 | 3,<br>107 |
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.2.4.**<br>Авлигын эсрэг хууль | тоо | 4 | 0 | 1 | 0 | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулсан гүйцэтгэх удирдлагын тоо | | | | | | |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨУЗХ, ЗУХ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.3.** Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтан (Орон нутгийн өмчийн удирдлага)-д чиглэсэн үйлчилгээ

<table>
<tr><th>№ 07 (23)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1-р арга хэмжээ<br>Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга, орон нутгийн өмчийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3, 78 дугаар зүйлийн 78.6, Стратегийн зорилт 2.4.1.</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 онд 2 аймагт ажиллаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргад орон нутгийн өмчийн удирдлагын асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байх.</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жил, жилийн эцэст:<br>- Орон нутгийн удирдлагын байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө хүссэн тухай бүрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч ажилласан байх.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах шийдвэрийн төслийг боловсруулан хүргүүлсэн.<br><br>Хөвсгөл, Дархан-Уул, Булган, Баянхонгор, Архангай, Төв, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тус аймгуудын орон нутгийн өмчөөс 2020 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хуулийн дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн хүсэлтийг судлан шийдвэрлэх чиглэлээр ажиллав. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад иргэдээс гомдол санал ирүүлсэн тул маргаантай асуудлыг орон нутагтаа шийдвэрлэсний дараа зөвшилцөх саналыг дахин ирүүлэх талаар хариу хүргүүлсэн. Төв аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтын тухайд тус хувьчлах эд хөрөнгийн харьяалах салбар яам болох ХХААХҮЯамнаас санал авах арга хэмжээг зохион байгуулж байна. Булган, Баянхонгор аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн талаар Эрүүл мэндийн яамнаас санал авахад дэмжигдээгүй тул зөвшилцөх асуудлыг шийдвэрлэх боломжгүй талаар албан бичгийг хүргүүлсэн.<br><br>Дархан-Уул, Архангай аймгаас ирүүлсэн хувьчлах эд хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах тухай асуудлыг судлан боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2020 оны 127, 469 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлүүлсэн байна.<br><br>Орон нутгийн өмчийн газар болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудад Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх агуулгын хүрээнд зөвлөмж, чиглэл өгч ажиллав.<br><br>21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын удирдлагуудтай санал солилцох, мэдээлэл өгөх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын сургалт, зөвлөгөөнийг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр онлайн хэлбэрээр зохион байгуулсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн асуудлыг холбогдох хуулийн дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн 6 аймгийн ИТХ-ын саналыг судалж, холбогдох шийдвэр гаргуулах, хариу өгөх чиглэлээр хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажилласан байна.<br>Түүнчлэн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан захиргааны байгууллага болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж, чиглэл өгсөн.<br>Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын асуудлаар мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 12 удаа (зайнаас, албан бичгээр)</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | 90 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 2.3.-ын үр дүн:** Орон нутгийн өмчийн удирдлага сайжирч, хууль тогтоомжийн хэрэгжилтэд ахиц гарсан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.1.** Орон нутгийн өмчийн асуудлаар өгсөн зөвлөгөө, дэмжлэг | Орон нутгийн тоо | 2 | Тухай бүр | 5 | Тухай бүр | 8 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.3.2.** Мэргэжил, арга зүйн удирдлага хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулахад оролцсон эсэх | тоо | - | Орон нутгийн хүсэлтийн дагуу оролцох | 3 | Орон нутгийн хүсэлтийн дагуу оролцох | 6 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.4.** Орон нутгийн өмчийн байгууллагын албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтанд (Нийслэл, орон нутгийн өмчийн байгууллагын албан хаагчдад) чиглэсэн.

| *№ 08 (24)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.1-р арга хэмжээ**<br>Орон нутгийн нэгжийн мэргэжилтнүүдэд сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨБАХ | | | | |
| | *Суурь түвшин* | - 2019 онд нийслэл, орон нутгийн өмчийн 22 байгууллагын давхардсан тоогоор 2100 албан хаагчид өмчийн харилцааны чиглэлээр нэгдсэн болон орон нутаг дахь сургалтыг 50 удаа зохион байгуулж, чадавхийг дээшлүүлсэн;<br>- Өмчийн харилцааны асуудлаар 50 удаа мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулсан байх;<br>- Сургалтын тоо;<br>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо;<br>- Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгийн тоо. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Эхний хагас жилд орон нутгийн өмчийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна;<br>- Зохион байгуулсан сургалтын тоо – 1,<br>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо (давхардсан тоогоор) - 88;<br>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 5 удаа (зайнаас, албан бичгээр). | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- ТӨБЗГ-т болон нийслэл, аймагт сургалт зохион байгуулсан байна;<br>- Зохион байгуулсан сургалтын тоо – 2,<br>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо (давхардсан тоогоор) – 200;<br>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 12 удаа (зайнаас, албан бичгээр). | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Тайлант хугацаанд зохион байгуулагдсан баруун болон зүүн бүсийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын уулзалт, семинарт ТӨБЗГ-ын төлөөлөл оролцож, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, хяналт шалгалтын чиглэлээр сургалт хийсэн.<br>21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын удирдлагуудтай санал солилцох, | | | | |

| | | |
|---|---|---|
| | | мэдээлэл өгөх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын сургалт, зөвлөгөөнийг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр онлайн хэлбэрээр зохион байгуулсан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | - ТӨБЗГ-т болон нийслэл, аймагт сургалт онлайн хэлбэрээр зохион байгуулсан;<br>- Зохион байгуулсан сургалтын тоо – 1;<br>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо – 200;<br>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 12 удаа (зайнаас, албан бичгээр). |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 2.4.-ийн үр дүн:** Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих чадавх сайжирсан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.4.1**<br>Зохион байгуулсан сургалт (давхардсан тоогоор) | тоо | 50 | 1 | 1 | 2 | 3 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.4.2**<br>Сургалтад хамрагдсан албан хаагчид (давхардсан тоогоор) | тоо | 2100 | 88 | 85 | 200 | 200 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.4.3**<br>Төрийн өмчийн бүртгэл, хөдөлгөөн, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, захиран зарцуулалтын асуудлаар зөвлөгөө, мэргэжил, арга зүйгээр хангасан байдал | тоо | 50 | 5 | 5 | 12 | 12 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨБАХ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 2.5.** Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандартыг сурталчилж, хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх

**Төрийн үйлчилгээний нэр, төрөл:** Мэргэжилтэй ажилтан (Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан)-д чиглэсэн.

| *№ 09 (25)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.5.1-р арга хэмжээ**<br>Өмчийн харилцааны асуудлаар төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨХШХ | | | | |
| | *Суурь түвшин* | - | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хуулийн этгээдийн тоо;<br>- Мэргэжил, арга зүйн зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчийн тоо. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хуулийн этгээдийн тоо - 10;<br>- Мэргэжил, арга зүйн зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчийн тоо – 20. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Хуулийн этгээдийн тоо - 29; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - Мэргэжил, арга зүйн зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчийн тоо - 70. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Хяналт шалгалтад хамрагдсан 29 хуулийн этгээдийн төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, хуулийн асуудал хариуцсан болон бусад холбогдох албан хаагч, нийт 108 албан хаагчид төрийн өмчийн эд хөрөнгө түүний хөдлөл, нягтлан бодох бүртгэлийн баримтын бүрдэл, худалдан авалтын үйл ажиллагаа болон тендерийн баримт бичгийн бүрдэл, өмчийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө, санал зөвлөмж өгөх, харилцан санал солилцож, уулзалт зохион байгуулах чиглэлээр ажилласан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хуулийн этгээдийн тоо - 10;<br>- Мэргэжил, арга зүйн зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчийн тоо – 29<br>**Жилийн эцэст:**<br>- Хуулийн этгээдийн тоо - 29;<br>- Мэргэжил, арга зүйн зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчийн тоо - 108. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 2.5.-ийн үр дүн:** Төрийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдын чадавх дээшилж, өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын үр нөлөө сайжирсан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 2.5.1**<br>Төрийн өмчийн харилцааны асуудлаар зөвлөгөө, мэргэжил, арга зүйгээр хангасан байдал | Төрийн өмчит хуулийн этгээдийн тоо | - | 10 | 10 | 29 | 29 |
| | | Албан хаагчийн тоо | - | 20 | 29 | 70 | 108 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ТӨХШХ

## ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

### (3.1. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ)

| № | Эрх зүйн акт | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Монгол улсын хууль №1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль | 1 | 2 | |
| 2. | Монгол улсын хууль №2. Орон сууц хувьчлах тухай хууль | 1 | 2 | |
| 3. | Монгол улсын хууль №3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль | 4 | 15 | |
| 4. | Монгол улсын хууль №4. Төрийн хяналт шалгалтын тухай хууль | 1 | 4 | |
| 5. | Монгол улсын хууль №5. Статистикийн тухай хууль | 1 | 1 | |
| 6. | Монгол улсын хууль №6. Ноот бичиг соёрхон батлах тухай хууль, 2019 он | 1 | 1 | |
| 7. | Засгийн газар хоорондын хэлэлцээр №1. БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны протокол, 1972, 1979, 1980 оны хэлэлцээр | 1 | 1 | |
| 8. | Засгийн газар хоорондын хэлэлцээр №2. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Хэлэлцээр | 1 | 1 | |
| 9. | УИХ-ын тогтоол №1. УИХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол: “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” | 1 | 1 | |
| 10. | Засгийн газрын тогтоол №1. Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоол: “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 11. | Засгийн газрын тогтоол №2. Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол: “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” | 3 | 8 | |
| 12. | Засгийн газрын тогтоол №3. Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоол: “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 13. | Засгийн газрын тогтоол №4. Засгийн газрын 2019 оны 91 дугаар тогтоол: ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14. | Засгийн газрын тогтоол №5. Засгийн газрын 2019 оны 186 дугаар тогтоол: “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 15. | Засгийн газрын тогтоол №6. Засгийн газрын 2019 оны 206 дугаар тогтоол: ““Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд баригдсан барилга байгууламжийн талаар авах арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 16. | Засгийн газрын тогтоол №7. Засгийн газрын 2019 оны 370 дугаар тогтоол: “Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 17. | Засгийн газрын тогтоол №8. Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол: “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 18. | Засгийн газрын тогтоол №9 Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол: ““Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 19. | Засгийн газрын тогтоол №10. Засгийн газрын 2020 оны 137 дугаар тогтоол: “Агаарын тээврийн салбарт авах зарим арга хэмжээний тухай” | 1 | 1 | |
| 20. | Ерөнхий сайдын захирамж №1. Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамж: “Ажлын хэсэг байгуулах тухай” | 1 | 1 | |
| 21. | Ерөнхий сайдын захирамж №2. Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамж: “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” | 4 | 17 | |
| 22. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №1.Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тэмдэглэл: “Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчид үнэ төлбөргүй шилжүүлж авсан үл хөдлөх хөрөнгийн тухай” | 1 | 1 | |
| **Нийт (Давхардсан тоогоор)** | | **30** | **63** | |

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Үндсэн чиг үүрэг №1.<br>Төрийн өмчийн удирдлага, зохицуулалт | 2 | 10 | 81.0 % |
| 2. | Үндсэн чиг үүрэг №2.<br>Төрийн өмчийн бүртгэл | 1 | 3 | 100.0 % |
| 3. | Үндсэн чиг үүрэг №3.<br>Төрийн өмчийн хяналт шалгалт | 1 | 4 | 97.5 % |
| **Нийт** | | **4** | **17** | **92.8 %** |

# ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.1.** Төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаар бодлого, чиглэл, шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

**Эрх зүйн акт:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4, 11 дүгээр зүйлийн 11.4, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол Улс Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд Ноот бичиг солилцох замаар 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Хэлэлцээр, Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тэмдэглэл.

<table>
<tr><th>№ 01 (26)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1-р арга хэмжээ<br>Төрийн өмчийг 2021-2024 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төсөл боловсруулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.1.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн;<br>- Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан;<br>- 2019 онд Засгийн газраас хууль тогтоомжийн уг төслийг эгүүлэн татсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Холбогдох судалгаа, тооцоолол хийсэн байх;<br>- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан байх;<br>- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулсан байна.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Судалгаа бүрэн хийгдэж дууссан байна;<br>- Үндсэн чиглэлийн үзэл баримтлалыг боловсруулсан байна;<br>- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан байна;<br>- Үндсэн чиглэлийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдсэн байна;<br>- Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийгдсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Холбогдох яамдаас санал авч нэгтгэсэн байна;<br>- ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна;<br>- Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төслийг Засгийн газарт хүргүүлсэн байна;<br>- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Монгол Улсын Их Хурал, үндсэн чиглэлийг Засгийн газар батлахаар тусгаж байгаа болно. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг болон хуулийн зөвлөх баг ажиллаж байна. Хууль батлагдсны дараа Үндсэн чиглэлийг батлуулах бэлтгэлийг хангах хүрээнд холбогдох судалгааны ажил хийгдэж байна.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор Төрийн өмчийг 2021-2024 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төсөл, Төрийн өмчийг 2021 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах зэрэг асуудлууд шийдвэрлэгдээгүй болно.<br>Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийн байдлыг нэгтгэн гаргаж, Засгийн газарт танилцуулсан.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">30 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 02 (27)</th><th>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td>Арга</td><td>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.2-р арга хэмжээ</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хэмжээний нэр, дугаар | Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг төслийг шинэчлэн боловсруулах, батлуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн үндэслэл:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.3. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг боловсруулсан байх;<br>- Холбогдох хууль тогтоомж, журамд нийцсэн байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Судалгаа бүрэн хийгдэж дууссан байна;<br>- Холбогдох яамдаас санал авч нэгтгэсэн байна;<br>- Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах тухай УИХ-ын шийдвэрийн төсөл боловсруулсан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Төслийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна;<br>- Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төслийг Засгийн газарт хүргүүлсэн байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрөөс хувьчилж үл болох эд хөрөнгийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, урьдчилсан жагсаалтын төслийг боловсруулсан. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах асуудал шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 30 хувь | | | | |

| *№ 03 (28)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.3-р арга хэмжээ**<br>Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн үндэслэл:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 11 дүгээр зүйлийн 11.4, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.3. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - 2019 онд дуудлагын худалдааг удаа дараа зарласан боловч сонирхогч этгээд байгаагүй. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Засгийн газрын шийдвэр гарсан байх;<br>- Дуудлага худалдааг нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан байх;<br>- Орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах арга хэмжээг авсан байна, тухай бүрд;<br>- Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан байна, тухай бүрд;<br>- Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан байна, тухай бүрд;<br>- Орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна;<br>- Өмчлөх эрхийн асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлсэн байна;<br>- Нээлттэй дуудлагын худалдааны тайланг гаргаж, мэдээлсэн байх. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоолоор Тээврийн цагдаагийн албаны 5 барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах үүргийг ТӨБЗГ-т өгсний дагуу 2019 онд нээлттэй дуудлага худалдааг удаа дараа доод үнийг бууруулан нийт 7 удаа | | | | |

| | | |
|---|---|---|
| | | зохион байгуулахад нэг ч оролцогч санал ирүүлээгүй. Иймээс тайлант онд Хууль зүй, дотоод хэргийн яамны санал авах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээ авах талаар шийдэлд хүрсэн. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Иймд Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны шинэ барилга барихтай холбогдуулан Тээврийн цагдаагийн албаны 5 барилга байгууламжийг шилжүүлэх саналыг Засгийн газарт хүргүүлсэн. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 70 хувь |

| *№ 04 (29)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.4-р арга хэмжээ**<br>Төрийн өмчийн орон сууцыг хувьчлах ажлыг зохион байгуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.3. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - 2019 онд төрийн өмчийн орон сууцыг хувьчлах ажлыг зохион байгуулах хүрээнд 47 иргэнд орон сууц эзэмших эрхийн бичиг олгосон. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Засгийн газрын шийдвэр гарсан байх;<br>- Эзэмшигчид эрхийн бичиг олгосон байх, тоогоор;<br>- Төрийн өмчийн орон сууцыг хууль журамд нийцүүлэн хувьчлах ажлыг зохион байгуулсан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жил, жилийн эцэст:**<br>- Төрийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу орон сууцыг хувьчлах асуудлыг судлан санал боловсруулах;<br>- ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;<br>- Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх;<br>- Засгийн газрын шийдвэрийг үндэслэн "Орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ"-г бүртгэн олгох;<br>- Засгийн газрын "Орон сууц хувьчлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар харьяалах Орон сууц хувьчлах товчоонд чиглэл өгөх, хяналт тавих. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Тайлант онд дараах төрийн өмчийн орон сууцыг эзэмшигчдэд нь үнэ төлбөргүй хувьчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангасан. Үүнд:<br>- Засгийн газрын 2020 оны 180 дугаар тогтоолын дагуу ХХААХҮЯ-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 айлын орон сууцыг;<br>- Засгийн газрын 2020 оны 210, 146 дугаар тогтоол, 34 дүгээр тэмдэглэлийн дагуу Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжиж ирсэн орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг;<br>- Засгийн газрын 2020 оны 145 дугаар тогтоолын дагуу "Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Дархан-Уул аймгийн Дархан сумын 13 дугаар багийн 10 дугаар хороолол, 13 дугаар байрны 8 айлын орон сууцыг;<br>- Засгийн газрын 2020 оны 173 дугаар тогтоолын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Дархан-Уул аймгийн Дархан сумын 13 дугаар багийн 10 дугаар хороолол, 13 дугаар байрны 6 айлын орон сууцыг.<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчдын орон сууцыг хувьчлах хүсэлтийг судлан хуулийн хүрээнд Засгийн газрын шийдвэр гаргах саналыг боловсруулахаар бэлтгэж байна. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Засгийн газрын тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг нь хангах ажлын хүрээнд орон сууцны 10 байрны 572 айлын орон сууцыг эзэмшигчдэд нь үнэ төлбөргүй хувьчлах ажлыг зохион байгуулж, хуулиар хүлээсэн үүргийн дагуу "Орон сууц эзэмших эрхийн бичиг"-ийг олгосон. Үүнтэй холбоотойгоор тухайн орон нутаг дахь орон сууц хувьчлах товчоонд "Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ" олгуулах хүсэлтийг хүргүүлж, өмчлөгчийн эрхийг баталгаажуулах арга хэмжээ авав. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь | | | | |

<table>
<tr><th>№ 05 (30)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.5-р арга хэмжээ<br>Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан орон сууцны 8 байрыг оршин суугчдад нь хувьчлах бэлтгэл ажлыг хангах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.1, Монгол Улс Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд Ноот бичиг солилцох замаар 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Хэлэлцээр, Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тэмдэглэл.</td></tr>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 онд байгуулсан Засгийн газар хоорондын Хэлэлцээрээр үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын өмчлөлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Орон сууцыг хувьчлах бэлтгэл ажлыг хангасан байх;<br>- Засгийн газрын шийдвэр гарсан байх;<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьчлах ажлыг зохион байгуулсан байх.</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жил, жилийн эцэст:<br>- Ажлын хэсэг байгуулан ажиллуусан байна;<br>- Оршин суугчдын судалгаа, мэдээллийг нэгтгэн нягтлан шалгах ажлыг гүйцэтгэж, эзэмшигчийг тогтоосон байна;<br>- Холбогдох маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан байна;<br>- ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн байна;<br>- Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх, шийдвэрлүүлсэн байна;<br>- Засгийн газрын шийдвэрийг үндэслэн “Орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ”-г бүртгэн олгосон байна;<br>- Засгийн газрын “Орон сууц хувьчлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар харьяалах Орон сууц хувьчлах товчоонд чиглэл өгөх, хяналт тавьсан байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Оросын Холбооны Улсын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах ажлыг зохион байгуулах хүрээнд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын орон сууц хувьчлалын мэдээллийн санд бүртгэлтэй эсэхэд тулгалт хийхэд хувьчилж авах хүсэлтээ ирүүлсэн 24 иргэн өмнө нь орон сууц хувьчилж авч байсан нь тогтоогдсон. Уг асуудлыг нягтлан шалгах, мэдээллийг тодруулах ажлуудыг дахин хийв.<br>Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлж авсан орон сууцны 8 байрны 505 айлын орон сууцыг эхний ээлжинд тухайн оршин суугчдад нь үнэ төлбөргүй хувьчлах тухай Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 210 дугаар тогтоол, 34 дүгээр тэмдэглэл гарсан болно. Мөн Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 146 дугаар тогтоолоор хувьчлагдаагүй үлдсэн 44 айлын орон сууцыг хувьчлах шийдвэр гаргасан. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Эдгээрээс 6 байрны 429 айлын орон сууц нь Улаанбаатар хотод, 2 байрны 120 айлын орон сууц нь Дархан-Уул аймагт байршилтай.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5">-</td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Засгийн газрын тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг нь хангах ажлын хүрээнд Оросын Холбооны Улсын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд шилжүүлэн авч, төрийн өмчид бүртгэсэн орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах ажлыг зохион байгуулж, “Орон сууц эзэмших эрхийн бичиг” олгосон. Уг эрхийн бичгийг олгосонтой холбогдуулан Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу тухайн орон нутаг дахь харьяалах Орон сууц хувьчлах товчоодод “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулж, өмчлөх эрхийг баталгаажуулах чиглэл өгөн хяналт тавив.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 06 (31)</th><th colspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="2">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.6-р арга хэмжээ<br>Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн</td><td>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3, 78 дугаар зүйлийн 78.6, Сртегийн зорилт 2.4.1.</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *уялдаа:* | | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - 2019 онд 6 аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг баталсан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалт батлах шийдвэр гарсан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жил, жилийн эцэст:**<br>- Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх талаар ирүүлсэн орон нутгийн удирдлагын хүсэлтийг хүлээн авч, судлах;<br>- Хувьчлах эд хөрөнгийн талаар харьяалах салбарын яамны саналыг авах;<br>- Шийдвэр гаргуулахад шаардлагатай холбогдох материал бүрдүүлж, бэлтгэх;<br>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;<br>- Шийдвэрийг албан бичгээр орон нутгийн удирдлагад хүргүүлэх;<br>- Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг шийдвэрлэсэн асуудлыг тайланд тусгасан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Хөвсгөл, Дархан-Уул, Булган, Баянхонгор, Архангай, Төв, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тус аймгуудын орон нутгийн өмчөөс 2020 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хуулийн дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн хүсэлтийг судлан шийдвэрлэх чиглэлээр ажиллав. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад иргэдээс гомдол санал ирүүлсэн тул маргаантай асуудлыг орон нутагтаа шийдвэрлэсний дараа зөвшилцөх саналыг дахин ирүүлэх талаар хариу хүргүүлсэн. Төв аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтын тухайд тус хувьчлах эд хөрөнгийн харьялах салбар яам болох ХХААХҮЯамнаас санал авах арга хэмжээг зохион байгуулж байна. Булган, Баянхонгор аймгийн орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн талаар Эрүүл мэндийн яамнаас санал авахад дэмжигдээгүй тул зөвшилцөх асуудлыг шийдвэрлэх боломжгүй талаар албан бичгийг хүргүүлсэн.<br><br>Дархан-Уул, Архангай аймгаас ирүүлсэн хувьчлах эд хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах тухай асуудлыг судлан боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2020 оны 127, 469 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлүүлсэн байна. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн асуудлыг холбогдох хуулийн дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн 6 аймгийн ИТХ-ын саналыг судалж, холбогдох шийдвэр гаргуулах, хариу өгөх чиглэлээр хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажилласан байна. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь | | | | |

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.1.-ийн үр дүн:** Бодлого, чиглэл, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.1.**<br>Засгийн газарт хүргүүлсэн бодлого, чиглэл болон хууль тогтоомжийн төсөл | тоо | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.2.**<br>Засгийн газарт хүргүүлсэн бодлого, чиглэл болон хууль тогтоомжийн төсөл холбогдох хууль, журамд нийцсэн эсэх | Тийм, үгүй | тийм | тийм | тийм | тийм | тийм |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.3.**<br>Хууль тогтоомжийн төсөл батлагдсан эсэх | Тийм, үгүй | үгүй | тийм | үгүй | тийм | үгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.4.** Хувьчлалаас гадуур худалдсан, шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийн тоо, үнэ | Тоо, сая төгрөг | - | 5, 10,000.0 | - | 5, 10,000.0 | - |
| 5. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.5.** Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан үл хөдлөх хөрөнгийн орлого төвлөрүүлэлт | Сая төгрөг | - | - | - | - | - |
| 6. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.6.** Төрийн өмчийн орон сууцыг хувьчлах шийдвэрийн хэрэгжилт | орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ олголтын тоо | 47 | 0 | 514 | 300 | 572 (100%) |
| 7. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.7.** ОХУ-ын өмчлөлөөс шилжүүлэн авсан орон сууцны 8 байрын хувьчлалын хэрэгжилт | орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ олголтын тоо | - | 300 | 505 | 549 | 549 (100%) |
| 8. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.1.8.** Орон нутгийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцсөн нутгийн удирдлагын байгууллага | Тоо | 6 | 10 | 3 | 21 | 6 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ, ТӨУЗХ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.2.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ашиг, орлогын хуваарилалтыг оновчтой тогтоож, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

**Эрх зүйн акт:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.3, $21^{1}$ дүгээр зүйлийн $21^{1}.2^{1}$, $21^{1}.3^{1}$ дэх хэсэг, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", УИХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 91, 2020 оны 127, 137 дугаар тогтоол.

| *№ 07 (32)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.1-р арга хэмжээ** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020-2022 оны зорилтын саналыг хянан нэгтгэж, санал дүгнэлтийн хамт Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.1, Стратегийн зорилт 2.4.1. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | .... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨУЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019-2021 оны зорилтын саналыг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Зорилтын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020-2022 оны зорилтын саналыг хүлээн авч, нэгтгэнэ;<br>- Саналыг хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Зорилтын саналыг тайлан мэдээнд тусгасан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020-2022 оны зорилтын саналыг хүлээн авч, нэгтгэсэн хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |

| | | |
|---|---|---|
| | *Хүрсэн түвшин* | Сангийн яамандзорилтын саналыг нэгтгэн хүргүүлсэн. Тайлан мэдээнд тусгагдсан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 08 (33)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.2-р арга хэмжээ<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоож, улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, хуулийн 1 дүгээр хавсралтын 15.5.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.1, Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2020 оны 137 дугаар тогтоол.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 онд 43 хуулийн этгээдээс төрийн өмчийн ногдол ашгийн 155.4 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>- ЗГҮААХХАХТ-ний 2020 оны зорилтот түвшинд 15.0 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр батлагдсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтийн хувь.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2019 оны санхүүгийн тайлангийн дүнд үндэслэн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөө (хувь, хэмжээг тусгасан)-г боловсруулсан байна;<br>- Ногдол ашгийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна;<br>- Төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьсан байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж, Сангийн яамтай тооцоо нийлсэн байна;<br>- Төрийн өмчийн ногдол ашгийн жилийн орлого ЗГҮАХХАХТ-нд тусгагдсаны дагуу 15.0 тэрбум төгрөгт хүрсэн байна;<br>- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсаны дагуу 173.0 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс Ирээдүйн өв санд 155.0 тэрбум төгрөгийн орлого, улсын төсөвт 18.0 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого төвлөрүүлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2019 оны санхүүгийн тайлангийн дүнд үндэслэн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөө (хувь, хэмжээг тусгасан)-г Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 315 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 53 хуулийн этгээдээс 173.6 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсон. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон ТӨБЗГ-ын дээр дурдсан тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажилласан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дүнгээр төрийн өмчийн ногдол ашгийн нийт 170.24 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна. “Эрдэнэс Монгол” ХХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг төвлөрүүлээгүй. “Улаанбаатар төмөр зам” ХНН дутуу төвлөрүүлэлттэй байна.<br>Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн 96.7 хувь буюу 162.93 тэрбум төгрөгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 100 хувийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй төрийн өмчит хуулийн этгээдээс төвлрүүлсэн байна.<br>Засгийн газрын хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу “МИАТ” ТӨХК-аас төрийн өмчийн ногдол ашиг авахгүйгээр шийдвэрлэсэн.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | 90 хувь |

<table>
<tr><th>№ 09 (34)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.3-р арга хэмжээ<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т тогтоосон онцгой дэглэмийг үргэлжлүүлэх, онцгой дэглэмийн үеийн ажлыг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2, УИХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 91, 2020 оны 127 дугаар тогтоол, Стратегийн зорилт 2.4.1,</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолоор онцгой дэглэм тогтоосон байдлыг УИХ-ын 2019 оны 74 тогтоол, Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоолоор 2 удаа сунгасан.<br>- УИХ-ын 2017 оны 23 дугаар тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны Н05/05 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- УИХ, Засгийн газрын холбогдох шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний үр дүн, хувиар;<br>- Цаашид авах арга хэмжээг тодорхойлсон байх;<br>- Засгийн газрын шийдвэр гарсан байх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т тогтоосон онцгой дэглэмийн байдалд хяналт тавьж, сар бүр тайлан мэдээг Засгийн газарт хүргүүлсэн байх;<br>- Онцгой дэглэм тогтоосон тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах;<br>- Онцгой дэглэмийн хугацаанд хийсэн ажлын үр дүнг тооцож, тайлан, дүгнэлт гаргасан байх;<br>- Тайлан, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд хийсэн ажлын үр дүн, тайланг хэлэлцэн цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын шийдвэр гарч, хэрэгжилтийг хангасан байна.<br>- Тайлан мэдээнд тусган мэдээлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т тогтоосон онцгой дэглэмийн үеийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Тэдгээр үйлдвэрийн газар сар бүр тайлан мэдээг Засгийн газарт хүргүүлж ажилласан.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар болон онцгой дэглэмийн хугацаар дуусгавар болгох талаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2020 оны 56 дугаар тэмдэглэл, 127 дугаар тогтоол гаргасан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар болон онцгой дэглэмийн хугацаар дуусгавар болгох талаар санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын хуралдааны 2020 оны 56 дугаар тэмдэглэл гаргасан. Уг тэмдэглэлд:<br>- “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа хангаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журам сайжруулж, үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, эдийн засгийн зорилтуудыг хангаж биелүүлснийг саашаан тэмдэглэсэн;<br>- “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр)-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх талтай хэлцэл хийн, санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх хүртэл онцгой дэглэмийн үед авч хэрэгжүүлж байсан ажлыг үргэлжлүүлэн үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг ердийн горимоор ажиллуулах шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, зохион байгуулж</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td>ажиллахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.<br><br>Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ““Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай” 127 дугаар тогтоол гаргасан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажилласан, тогтоолын хэрэгжилт жилийн эцсийн дүнгээр 88.0 хувийн гүйцэтгэлтэй байна. ТӨБЗГ-аас Засгийн газрын ажлын хэсэгт материал, мэдээллийг гаргаж өгч ажилласан.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td>100 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 10 (35)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.4-р арга хэмжээ<br>Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан болон өөрчлөн байгуулагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм батлах, зохион байгуулалтын бүтцийн асуудлыг шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.3, Засгийн газрын 2019-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний арга хэмжээ 5.2.1.2, Стратегийн зорилт 2.4.1, Засгийн газрын 2019 оны 186, 206, 370.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа “Биокомбинат” УТҮГ;<br>- “Замын-Үүдийн дулааны станц” болон тус станцын ус, дулаан хангамж, ариутгах татуургын байгууламж, түүний инженерийн шугам сүлжээний ашиглалтын үйл ажиллагааг хариуцах чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээд байхгүй;<br>- Засгийн газрын 2015 оны “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоол хэрэгжээгүй.<br>- Эдгээртэй холбоотой Засгийн газрын шийдвэр гарсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байх;<br>- Төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төсөв батлагдсан байх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төсөв, удирдлагыг томилох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх арга хэмжээ авсан байна;<br>- Удирдлага, зохион байгуулалтын асуудлыг боловсруулж, бэлтгэсэн байна;<br>- Асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Засгийн газрын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна;<br>- Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байна.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Засгийн газрын 2019 оны “Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 370 дугаар тогтоолын дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, албан тушаалын жагсаалт, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, үйлдвэрийн газрын захирлыг томилон хэвийн үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн боловч Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны саналаар Засгийн газрын шийдвэр гарч, улсын төсөвт үйлдвэрийн газар болон өөрчлөн зохион байгуулсан.<br><br>Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 123 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон Замын-Үүдийн чөлөөт бүсийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний халуун усаар хангах, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаар хариуцан гүйцэтгэх үүрэг бүхий “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг нь баталсан. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 419 дүгээр тогтоолоор “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг томилж, 533 дугаар тогтоолоор уг үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг баталсан.<br><br>ТӨБЗГ-ын хуралдаанаар зарим төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэмд</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | өөрчлөлт оруулах, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах асуудлыг судлан боловсруулж, шийдвэрлүүлсэн байна. Үүнд:<br>- “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулах, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай;<br>- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай;<br>- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг батлах тухай;<br>- “Монголросцветмет” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг батлах тухай;<br>- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК- ийн дүрмийн 4.2 заалтад холбогдох өөрчлөлтийг оруулах тухай;<br>- “Баянчандмань АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;<br>- “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | ТӨБЗГ нь хуулиар хүлээсэн үүргийн дагуу тогтоол гаргаж, төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэмд өөрчлөлт оруулах, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэсэн:<br>- Засгийн газрын шийдвэрээр шинээр байгуулагдсан 2 хуулийн этгээдийн дүрэм, орон тооны хязгаар, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг баталж, удирдлагыг томилон үйл ажиллагааг нь эхлүүлсэн;<br>- Төрийн өмчит 5 хуулийн этгээдийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэсэн;<br>- Төрийн өмчит 4 хуулийн этгээдийн орон тооны хязгаар, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.2-ын үр дүн:** Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөө биелсэн байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.2.1.**<br>Улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашиг (Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд заасан хэмжээгээр) | Тэрбум төгрөг | 4.2 | 7.0 | 2.3 | 18.0 | 15.2<br>(84.4%) |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.2.2.**<br>Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашиг (Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд заасан хэмжээгээр) | Тэрбум төгрөг | 151.5 | 60.0 | 150.0 | 155.0 | 155.0<br>(100%) |

Мэдээллийн эх сурвалж: Легалинфо эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.3.** Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтыг оновчтой удирдлага, зохицуулалтаар хангаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулан, төрийн өмчийн бүртгэл, мэдээллийг тодорхой болгох, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Эрх зүйн акт:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.8 дахь хэсэг, 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Стратегийн зорилт 2.4.2.

| *№ 11 (36)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.1-р арга хэмжээ**<br>Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлаарх Ерөнхий сайдын томилсон Ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах, Дэд ажлын хэсгийг ажиллуулах, |

<table>
<tr><td></td><td colspan="6">холбогдох судалгаа, тооцоог хийх, ТӨБЗГ-ын саналыг бэлтгэх</td></tr>
<tr><td></td><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны протокол, 1972, 1979, 1980 оны хэлэлцээр, УИХ-ын 2019 оны “Ноот бичиг соёрхон батлах тухай” хууль, Ерөнхий сайдын 2016 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 91 дүгээр захирамж.</td></tr>
<tr><td>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td></td><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td></td><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨБАХ, ТӨУЗХ</td></tr>
<tr><td></td><td>Суурь түвшин</td><td colspan="5">- Засгийн газар хоорондын хэлэлцээр, протоколын нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлуулсан;<br>- ОХУ-ын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд орон сууцны 8 байрыг шилжүүлэн хүлээн авах ажиллагааг зохион байгуулсан.</td></tr>
<tr><td></td><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- ОХУ-аас шилжүүлэн авсан хөрөнгийг Монгол Улсын өмчид хүлээн авах, бүртгэх асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэр гаргуулах;<br>- ОХУ-ын талаас хүлээн авсан орон сууцны 8 байрыг хувьчлах асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэр гаргуулах, хувьчлах ажлыг зохион байгуулах;<br>- Ажлын хэсгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх.</td></tr>
<tr><td></td><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- ОХУ-аас шилжүүлсэн хөрөнгийг Монгол Улсын өмчид хүлээн авч бүртгэх, орон сууцны 8 байрыг хувьчлах асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэр гаргуулсан байх;<br>- Хэрэгжилтийг зохион байгуулсан байх.</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="5">Жилийн эцэст:<br>- ОХУ-ын талаас ирүүлэх албан бичиг, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Монгол Улсын Засгийн газар, Оросын холбооны Улсын Засгийн газар хооронд Ноот бичиг солилцох замаар 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Хэлэлцээрийн хавсралтад заасан Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч бүртгэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тэмдэглэлээр шийдвэрлүүлсэн. Мөн ийнхүү шилжүүлэн авсан орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах асуудлыг судлан шийдвэрлүүлэх асуудлаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020 оны 210, 146 дугаар тогтоолоор уг 549 айлын орон сууцыг оршин суугчдад нь үнэ төлбөргүй хувьчлахаар шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу оршин суугчдад нь “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг ТӨБЗГ-аас олгож, “Өмчлөгчийн эрхийн гэрчилээ” олгуулах хүсэлтийг харьяалах Орон сууц хувьчлах товчоодод хүргүүлсэн байна.<br><br>ОХУ-аас шилжүүлэн авсан орон сууцны 8 байранд оршин суугаа Оросын цагаач иргэдэд орон сууц хувьчлах эрх зүйн үндэслэлийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яаманд албан бичиг хүргүүлсэн. Гадаад харилцааны яамнаас чиглэл хүлээн авч, хувьчлалд хамрагдах орон сууцанд амьдарч буй иргэдээс өргөдөл хүлээн авч, судлан, хувьчлах орон сууц, хувьчилж авах иргэдийн жагсаалт, шийдвэрийн төслийг бэлтгэж байна.<br><br>ОХУ-ын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд хүлээн авсан орон сууцны 8 байр, тэдгээрийг дагалдах дулаан, цахилгааны дэд станцын өмчлөх эрхийн гэрчилгээний эх хувь болон бусад холбогдох баримтыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн газарт хүргүүлж, ОХУ-ын нэр дээрх үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүлэв.<br><br>ОХУ-ын Монгол дахь өмчийн асуудлаар ОХУ-ын Төлөөлөгчийн газрын удирдлагатай уулзалт зохион байгуулсан.</td></tr>
<tr><td></td><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td></td><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">- ОХУ-аас шилжүүлсэн хөрөнгийг Монгол Улсын өмчид хүлээн авч бүртгэх, орон сууцны 8 байрыг хувьчлах асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлсэн.<br>- Хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

| № 12 (37) | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|
| Арга | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.2-р арга хэмжээ** |

<table>
<tr><td>хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэх, актлах, данснаас хасах, шилжүүлэх, ашиглалтын хугацааг тогтоох асуудлыг зохицуулах, хэрэгжилтийг хангуулах, эд хөрөнгийн бүртгэл мэдээллийг баяжуулах</td></tr>
<tr><td></td><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.5, 11.8 дахь хэсэг, 24, 25, 30, 31 дүгээр зүйл, Стратегийн зорилт 2.4.2, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоол, 2020 оны 10 дугаар тогтоол.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨБАХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд ТӨБЗГ-ын хуралдаанаар дараах хөрөнгийн хөдөлгөөний зохицуулалтын асуудлыг шийдвэрлэсэн:<br>- Төрийн өмчит 962 хуулийн этгээдийн 1,942.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах, бүртгэх, шилжүүлэх хөрөнгийн хөдөлгөөн;<br>- 19 аймгийн (давхардсан тоогоор) төрийн өмчөөс орон нутгийн өмчид, орон нутгаас төрийн өмчид 10.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгө шилжүүлэх асуудал.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх хүсэлт өгсөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо;<br>- Хөрөнгийн хөдөлгөөнийг санхүүгийн тайлантай тулган баталгаажуулсан эсэх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Төрийн болон орон нутгийн өмчит 320 хуулийн этгээдийн өмчийг бүртгэх, актлах, данснаас хасах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Төрийн болон орон нутгийн өмчит 650 хуулийн этгээдийн өмчийг бүртгэх, актлах, данснаас хасах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байна;<br>- Дүн мэдээг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн байна;<br>- Төрийн өмчит 1100, орон нутгийн өмчит 4920 хуулийн этгээдийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг санхүүгийн тайлан балансхтай тулган баталгаажуулж, тайлагнасан байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн өмчит хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн хөрөнгийн зохицуулалттай холбоотой санал, хүсэлтийг судлан боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллав. 2020 оны жилийн эцсийн дүнгээр, ТӨБЗГ-ын 449 тогтоол, газрын даргын 272 албан бичгээр давхардсан тоогоор 1650 хуулийн этгээдийн 2,084.2 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий 84090 нэрийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэж, төрийн өмчийн эд хөрөнгийн зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу хийсэн байна.<br><br>Хөрөнгийн зохицуулалтыг төрлөөр нь ангилан танилцуулбал:<br><br>- 846 хуулийн этгээдийн 37676 нэрийн 353.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах;<br>- 330 хуулийн этгээдийн 4465 нэрийн 787.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх;<br>- 235 хуулийн этгээдийн 3619 нэрийн 899.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэх;<br>- 52 хуулийн этгээдийн 178 нэрийн 10.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг олж авах;<br>- 134 хуулийн этгээдийн 304 нэрийн 9.96 тэрбум төгрөгийн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах;<br>- 53 хуулийн этгээдийн 23.05 тэрбум төгрөгийн балансын дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 37848 нэрийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг 10.89 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоох.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">- Төрийн өмчит 1650 (давхардсан тоогоор) хуулийн этгээдийн 2,084.2 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий 84090 нэрийн өмч хөрөнгийг бүртгэх, актлах, данснаас хасах, шилжүүлэх, олох, худалдах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлэсэн;<br>- Төрийн өмчит 1100, орон нутгийн өмчит 4920 хуулийн этгээдийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлийг санхүүгийн тайлан балансхтай тулган баталгаажуулсан;<br>- Дүн мэдээг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

| *№ 13 (38)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|

| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.3-р арга хэмжээ**<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн “Захиргааны статистикийн мэдээлэл”-ийг боловсруулж тайлагнах, дүн шинжилгээ хийх, танилцуулга, лавлагаа бэлтгэж тайлагнах | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Стратегийн зорилт 2.4.2. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨБАХ | | | | |
| | *Суурь түвшин* | Төрийн өмчит 1052 хуулийн этгээд, орон нутгийн өмчит 4800 хуулийн этгээдийн өмчийн захиргааны статистик мэдээллийг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Захиргааны статистикийн маягтын дагуу мэдээлэл өгсөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо;<br>- Мэдээллийг нэгтгэн тайлагнасан эсэх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Төрийн өмчит 1000, орон нутгийн өмчит 4800 хуулийн этгээдийн төрийн өмчийн мэдээллийг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Төрийн өмчит 1000, орон нутгийн өмчит 4800 хуулийн этгээдийн төрийн өмчийн мэдээллийг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн байна. Эхний хагас жилд хийгдсэн байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчийн захиргааны статистик мэдээллийг 17 маягтаар төрийн өмчийн 1000 гаруй хуулийн этгээдээс цуглуулан нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Орон нутгийн өмчийн нийт 4800 гаруй хуулийн этгээдээс захиргааны статистик мэдээллийг Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар хариуцан цуглуулж, нэгтгэн ирүүлснийг хүлээн авч, улсын дүн, нэгтгэлийг албан бичгээр болон цахимаар Үндэсний статистикийн хороонд 3 дугаар сарын 15-нд буюу хуулийн хугацаанд багтаан хүргүүлсэн.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан мэдээг Сангийн яам, Үндэсний Аудитын газарт цахимаар хүргүүлсэн. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Төрийн өмчит 1000, орон нутгийн өмчит 4800 хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг батлагдсан маягтын дагуу цуглуулан нэгтгэж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.<br>Мөн тэдгээрийн хөрөнгийн хөдөлгөөнийг санхүүгийн тайлан балансатай тулган баталгаажуулж, тайлагнасан. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь | | | | |

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.3.-ын үр дүн:** Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, өмчийн үр ашиг, бүртгэл, мэдээллийн чанар дээшилсэн байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.1.**<br>ОХУ-ын талаас хүлээн авсан хөрөнгийг Монгол Улсын өмчид бүртгэх ажлын хэрэгжилт | Хэрэгжил-тийн хувь | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.2**<br>ОХУ-аас хүлээн авсан орон сууцны 8 байрыг орших суугчдад нь хувьчлах ажлын хэрэгжилт | Хэрэгжил-тийн хувь | - | 100 | 75.0 | 100 | 100 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.3**<br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн | Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн | 962 | 320 | 320 | 650 | 1650 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | балансад бүртгэлтэй эд хөрөнгийн хөдөлгөөний зохицуулалт | тоо | | | | | |
| | | Хэрэгжил-тийн хувь | 100 | 48.0 | 40.0 | 100 | 100 |
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.4** Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй эд хөрөнгийн хөдөлгөөний зохицуулалт бүхий ТӨБЗГ-ын шийдвэрийн хэрэгжилт | Гарсан шийдвэ-рийн тоо | 245 тогтоол | 180 тогтоол, 160 албан бичиг | 183 тогтоол, 160 албан бичиг | 300 тогтоол, 350 албан бичиг | 449 тогтоол, 272 албан бичиг |
| | | Хэрэгжил-тийн хувь | 90.0 | 80.0 | 35.0 | 90.0 | 90.0 |
| 5. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.5** Хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлан балансгай тулган баталгаажуулсан эсэх | Хуулийн хугацаанд | 4 дүгээр сарын 25-ны дотор | - | - | 7 дугаар сарын 25-ны дотор | 7 дугаар сарын 25-ны дотор |
| | | Хуулийн этгээдийн тоо | 6012 | 1100 ТӨХЭ | - | 1100 ТӨХЭ, 4920 ОНӨХЭ | 1100 ТӨХЭ, 4920 ОНӨХЭ |
| 6. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.6** Төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистик мэдээллийг маягтын дагуу цуглуулах | Хамраг-дах хуулийн этгээд | 1052 ТӨХЭ | 1000 ТӨХЭ, 4800 ОНӨХЭ | 1000 ТӨХЭ, 4800 | 1000 ТӨХЭ, 4800 ОНӨХЭ | 1000 ТӨХЭ, 4800 |
| 7. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.3.7** Мэдээллийг нэгтгэн боловсруулж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн эсэх | Хуулийн хугацаанд | 3 дугаар сарын 15-ны дотор | 3 дугаар сарын 15-ны дотор | 3 дугаар сарын 15-ны дотор | 3 дугаар сарын 15-ны дотор | 3 дугаар сарын 15-ны дотор |

Мэдээллийн эх сурвалж: УИХ, ЗГХЭГ, Үндэсний Статистикийн хороо,ТӨБЗГ-ын ТӨБАХ

## ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.4.** Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад мэргэжлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

**Эрх зүйн акт:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.2, 66.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^1$, $5^2$, $5^3$ дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний зорилт, арга хэмжээ 2.1.6, 2.1.7, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр".

| *№ 14 (39)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.1-р арга хэмжээ**<br>Төрийн өмчийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөө боловсруулах, батлах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, 66.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^1$, $5^3$ дугаар зүйл, ЗГҮАХХАХТ-ний арга хэмжээ 1.4.6, 1.4.7, Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоол, Стратегийн зорилтын 2.4.3. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨХШХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд:<br>- Төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 30 хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийсэн. Үүнээс 4 хуулийн этгээдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.<br>- Шалгалтаар нийт 62.0 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлсэн байна. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хяналт шалгалтын ажлын 2020 оны төлөвлөгөө, хуваарийг боловсруулж батлуулсан байх;<br>- Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо;<br>- Шалгалтын удирдамжийг тухай бүр батлуулсан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:** | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td>- Хяналт шалгалтын ажлын 2020 оны төлөвлөгөө, хуваарийг боловсруулж газрын даргын тушаалаар батлуулсан байна, 2-р сард;<br>- Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо - 10;<br>- Хяналт шалгалтын ажлын удирдамжийг тухай бүр батлуулсан байх.</td></tr>
<tr><td></td><td></td><td>Жилийн эцэст:<br>- Хяналт шалгалтын ажлын удирдамжийг тухай бүр батлуулан хэрэгжүүлсэн байх;<br>- Төрийн өмчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө бүрэн биелсэн байна;<br>- Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо - 39.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td>ТӨБЗГ-аас 2020 онд хэрэгжүүлэх төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулсан.<br><br>Батлагдсаны төлөвлөгөөний дагуу, газрын даргын тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын ажил хийгдсэн. Тайлант жилд баримтын шалгалтыг 19 хуулийн этгээдэд, системийн шалгалтыг 10 хуулийн этгээдэд, гүйцэтгэлийн шалгалтыг 10 хуулийн этгээдэд, нийт 39 хуулийн этгээдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн. Тайлант жилд нийт 32 хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 82.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбоотой улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, томилолтын зардлыг царцаасан зэрэг шалтгаанаар орон нутагт ажиллахаар төлөвлөсөн хяналт шалгалтын ажил хэрэгжих боломжгүй болсон нь төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлсөн.<br><br>Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 7 шалгалтыг удирдамжийн дагуу хийж, холбогдох байгууллагад хяналт шалгалтын тайланг хүргүүлсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалт, үндсэн болон санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг боловсруулж, ТӨБЗГ-ын даргаар батлуулсан.</td></tr>
<tr><td></td><td>Зарцуулсан хөрөнгө</td><td>-</td></tr>
<tr><td></td><td>Хүрсэн түвшин</td><td>- Хяналт шалгалтын ажлын 2020 оны төлөвлөгөө, хуваарийг боловсруулж газрын даргын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан;<br>- Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт 82.5 хувь;<br>- Нийт хэрэгжүүлсэн хяналт шалгалт 37, Үүнээс төлөвлөгөөт 32, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 7;<br>- Хэрэгжүүлсэн баримтын шалгалт 15, системийн шалгалт 7, гүйцэтгэлийн шалгалт 10;<br>- Хяналт шалгалтын ажлын удирдамжийг тухай бүр батлуулан ажилласан;<br>- 2021 онд хийх хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. Нийт 35 хуулийн этгээдэд төрийн өмчийн хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td>100 хувь (Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас хэрэгжих боломжгүй болсон хяналт шалгалтын ажлыг тооцоогүй)</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 15 (40)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td>Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.2-р арга хэмжээ<br>Төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх</td></tr>
<tr><td></td><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^3$ дугээр зүйл, Стратегийн зорилтын 2.4.3.</td></tr>
<tr><td>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td></td><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td></td><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨХШХ</td></tr>
<tr><td></td><td>Суурь түвшин</td><td colspan="5">-</td></tr>
<tr><td></td><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо;<br>- Хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж тайлагнасан байх;<br>- Хяналт шалгалтын үр дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан байх.</td></tr>
<tr><td></td><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>-</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдах төрийн өмчит болон төрийн</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо -10;<br>- Хяналт шалгалтын дүнг нэгтгэж тайлан, танилцуулга бэлтгэсэн байна;<br>- Гүйцэтгэлийн шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2020 онд гүйцэтгэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 7 хуулийн этгээд, 2019 онд хяналт шалгалтад он дамнуулж хамрагдсан 3 хуулийн этгээд нийт 10 хуулийн этгээдэд хүргүүлсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлт, шалгалтын тайлангаар өгсөн үүрэг даалгавар, цаашид авах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.<br><br>Дээрх шалгалтын үр дүнгээр зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа байдал, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн ногдол ашиг болон түрээсийн орлогыг төвлөрүүлсэн зэрэг үр дүн гарсан бөгөөд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас 2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах боломжгүй болсон. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | - Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо -10;<br>- Хяналт шалгалтын дүн, тайланг боловсруулан бэлтгэж байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь |

<table>
<tr><th>№ 16 (41)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.3-р арга хэмжээ<br>Төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад төлөвлөгөөт бус шалгалтыг хэрэгжүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^2$ дугаар зүйл, Стратегийн зорилтын 2.4.3.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ТӨХШХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд:<br>- Төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо – 4;<br>- Хяналт шалгалтын үр дүнг тайлагнан баталгаажуулсан байдал – 100 хувь.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо;<br>- Ажлын хэсэг байгуулсан байх, тухай бүр;<br>- Хяналт шалгалтын үр дүнг тайлагнаж, баталгаажуулсан байдал, хувиар.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Ажлын хэсэг байгуулсан байх, тухай бүр;<br>- Шалгалтын удирдамж батлуулсан байх, тухай бүр;<br>- Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Ажлын хэсэг байгуулсан байх, тухай бүр;<br>- Шалгалтын удирдамж батлуулсан байх, тухай бүр;<br>- Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд төлөвлөгөөт бус 7 хяналт шалгалтыг хэрэгжүүлж, тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. Үүнд:<br><br>1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/23 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Хичээнгүйтэй холбоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны ХЭГ/296 тоот албан бичигт дурдсан мэдээллийг нягталж санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А-1/723 дугаар албан бичгээр ажлын хэсгийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д хүргүүлсэн.<br><br>2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Э.Тэгшжаргалтай холбоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны ХЭГ/3522 тоот албан бичигт</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | дурдсан мэдээллийг нягталж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А-1/260 дугаар албан бичгээр ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/24 дүгээр тушаал, 5 дугаар сарын 07-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оноос хойших санхүүгийн баримтыг шалгаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг 2 удаа тус тус байгуулан ажиллуулж, тайлан, санал дүгнэлттэй танилцаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан.<br><br>4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 63 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд хяналт шалгалтын мэргэжилтнүүд ажиллаж, тайланг Ажлын дэд хэсэгт хүргүүлсэн.<br><br>5.Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн удирдамжийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2016-2020 онуудын хөрөнгө оруулалтын болон баримтын иж бүрэн шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хяналт шалгалтын болон бусад мэргэжилтнүүд ажиллаж байна.<br><br>6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Нью Тур Сафарис” ХХК-ийн хооронд үүссэн төрийн өмчийн түрээсийн гэрээ, түүнтэй холбоотой асуудлыг хянан шалгаж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсны дүнд төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн төлбөр төлөхөөр болсон. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | - ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайд, ТӨБЗГ-ын даргын шийдвэр, удирдамжийн дагуу холбогдох ажлын хэсэгт албан хаагчид ажиллаж, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн;<br>- Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг тухай бүр хийсэн;<br>- Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 17 (42)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.4-р арга хэмжээ**<br>Хяналт шалгалтын бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, баяжуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэг, Стратегийн зорилтын 2.4.3. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | Улирал | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ТӨХШХ | | | | |
| | *Суурь түвшин* | - | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сангийн агуулгыг тогтсон байх;<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хөтөлсөн байх;<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн баяжилт, хувиар. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сангийн агуулгыг тогтсон байна;<br>- Бүртгэл мэдээллийн санд бүртгэх хуулийн этгээдийн тоо - 10;<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн баяжилт, 100 хувь байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сангийн агуулгыг тогтсон байна;<br>- Бүртгэл мэдээллийн санд бүртгэх хуулийн этгээдийн тоо - 29;<br>- Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн баяжилт, 100 хувь байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сангийн агуулгыг шалгалтад хамрагдсан хуулийн этгээд, шалгалт хийх үндэслэл, шалгалтын хамрах хүрээ, хийх хугацаа, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, илэрсэн зөрчил дутагдал, мөнгөн дүн, тогтоолын огноо, дугаар, биелэлт зэрэг мэдээллээр тогтсон.<br><br>Баримтын хяналт шалгалт хийсэн төрийн өмчит хуулийн этгээдийн дүнгийн мэдээллийн нэгтгэлийн нэгдсэн сан дээр дурдсан агуулгын хүрээнд шинээр | | | | |

| | | |
|---|---|---|
| | | үүсгэн хөтөлж, тухай бүр баяжилтыг хийсэн.<br>2016-2019 онуудад баримтын хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдүүдийн гаргасан зөрчил, дутагдлыг эрх зүйн актаар нь судалж ангилан мэдээллийн нэгдсэн санд оруулсан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | - Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн агуулгыг тогтож, хүснэгт боловсруулсан;<br>- Хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, мэдээллийг 100 хувь оруулж баяжуулан ашиглаж эхэлсэн;<br>- Хяналт шалгалтын бүртгэл хөтөлсөн хуулийн этгээдийн тоо – 32;<br>- Хяналт шалгалтын бүртгэлийн иж бүрдэл, нэгдсэн сангийн баяжилт - 100 хувь. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

**Гүйцэтгэлийн зорилт № 3.1.4.-ийн үр дүн:** Мэргэжлийн хяналт шалгалтын үр дүнд ахиц гарч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.4.1.** Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо | тоо | - | - | - | 10 | 10 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.4.2** Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх төлөвлөгөөний биелэлт | хувь | - | - | - | 100 | 90 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.4.3** Шалгалтын дүнгээр гарсан тогтоол шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт | хувь | - | - | - | 80 | Дүн гараагүй |
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.4.4** Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгасан төрийн өмчит хуулийн этгээдийн тоо | Тоо | - | - | - | 4< | Дүн гараагүй |
| 5. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.4.5** Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн хөтлөлт, сангийн бүрдүүлэлт | Хяналт шалгал-тад хамрагд-сан хуулийн этгээдийн тоо | 30 | 10 | 10 | 29 | 32 |
| | | Хэрэгжил-тийн хувь | - | 100 | 100 | 100 | 100 |
| 6. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.1.6** Төрийн өмчийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөө боловсруулах, батлах | Хэрэгжил-тийн хувь | 100 | - | - | 100 | 100 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ, ТӨХШХ

## ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

### (3.2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ)

| № | Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтууд | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах | 1 | 27 | 92.6 % |
| 2. | Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх | 1 | 5 | 96.0 % |
| 3. | Төсөв, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах | 1 | 9 | 96.7 % |
| **Нийт** | | **3** | **41** | **95.1 %** |

# ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.1.** Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах

<table>
<tr><th>№ 01 (43)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.1-р арга хэмжээ<br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнах, мэдээлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Засгийн газрын 1996 оны “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">Түвшинг аргачлалд заасны дагуу 2-3 жилийн дунджаар авав:<br>- Хэрэгжилтийн дундаж хувь буюу үнэлгээ – 86.0% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” (2017 он 81.3%, 2018 он 92.5%, 2019 он 86.7%);<br>- ЗГХЭГ-т тайланг тогтоосон хугацаа, хуваарийн дагуу хүргүүлсэн (жилд 2 удаа тайлагнан мэдээлсэн).</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Хэрэгжилтийн хувь, тайлагнасан хугацаа</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Хэлтэс, албад хариуцсан чиг үүрэгтээ хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байна;<br>- Хэрэгжилтийн хувь буюу үнэлгээ, байгууллагын дүнгээр: 90< хувь буюу “Үр дүнтэй” байна;<br>- Холбогдох журамд заасан хугацаа, хуваарийн дагуу нэгтгэсэн тайланг ЗГХЭГ-т 2 удаа хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Хэлтэс, албад хариуцсан чиг үүрэгтээ хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байна;<br>- Хэрэгжилтийн хувь буюу үнэлгээ, байгууллагын дүнгээр: 90<% буюу “Үр дүнтэй” байна;<br>- Холбогдох журамд заасан хугацаа, хуваарийн дагуу нэгтгэсэн тайланг ЗГХЭГ-т 2 удаа хүргүүлсэн байна;<br>- Хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоолоор 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн болон 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт журамд заасан хугацаанд 2 удаа тайлагнасан. Тайланг ТӨБЗГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээд гаргасан шийдвэр, ХШҮ-ний тайлангийн хамт 2020 оны А-1/169 болон А-1/1230 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нэгдсэн систем http://new.unelgee.gov.mn –д оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулсан байна.<br>Тайлан, холбогдох материал, хянал-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээ болон цахим хуудсанд байршуулан мэдээлж, албан хаагчид, олон нийтэд танилцуулах арга хэмжээ авсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ТӨБЗГ-ын хариуцан болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 4 бүлэг бодлогын хүрээний 7 тэргүүлэх зорилтод хамаарах 22 арга хэмжээний тухайн жилийн зорилтот</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | түвшингийн хүрсэн түвшингийн биелэлтээр тайлагнасан болно. 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 86.7 хувь, 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 75.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 02 (44)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.2-р арга хэмжээ<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, тайлагнах, мэдээлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Засгийн газрын 1996 оны “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="8">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">Түвшинг аргачлалд заасны дагуу 2-3 жилийн дунджаар авав:<br>- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж хувь буюу үнэлгээ – 90.0 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” (2016 он 91.7, 2017 он 86.1%, 2018 он 95.1%, 2019 он 88.5%);<br>- ЗГХЭГ-т тайланг тогтоосон хугацаа, хуваарийн дагуу хүргүүлсэн (жилд 2 удаа тайлагнан мэдээлсэн).</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Хэрэгжилтийн хувь, тайлагнасан хугацаа</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Хэлтэс, албад хариуцсан чиг үүрэгтээ хамаарах тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, тайлагнасан байна;<br>- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь буюу үнэлгээ, байгууллагын дүнгээр: 90< хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” байна;<br>- Холбогдох журамд заасан хугацаа, хуваарийн дагуу нэгтгэсэн тайланг ЗГХЭГ-т 2 удаа хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Хэлтэс, албад хариуцсан чиг үүрэгтээ хамаарах тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, тайлагнасан байна;<br>- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь буюу үнэлгээ, байгууллагын дүнгээр: 90< хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” байна;<br>- Холбогдох журамд заасан хугацаа, хуваарийн дагуу нэгтгэсэн тайланг ЗГХЭГ-т 2 удаа хүргүүлсэн байна;<br>- Хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="6"></td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Засгийн газрын тогтоолоор 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн болон 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт журамд заасан хугацаанд 2 удаа тайлагнасан. Тайланг ТӨБЗГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээд гаргасан шийдвэр, ХШҮ-ний тайлангийн хамт 2020 оны А-1/60 болон А-1/1228 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нэгдсэн систем http://new.unelgee.gov.mn –д оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулсан байна.<br>Тайлан, холбогдох материал, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээ болон цахим хуудсанд байршуулан мэдээлж, албан хаагчид, олон нийтэд танилцуулах арга хэмжээ авсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">2019 оны жилийн эцсийн дүн:<br>- нийт 6 төрлийн 62 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох 107 заалтын хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд хэрэгжилтийн дүн 88.5 хувийн гүйцэтгэлтэй. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн хэрэгжилт тогтмолжин хэвшсэн, ач холбогдолгүй болсон, дараагийн шийдвэр гарсан, бүрэн хэрэгжсэн, хугацаа дууссан нийт 5 төрлийн 31 шийдвэрийн 40 заалтыг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системийн хяналтаас хасуулах арга хэмжээ авч, дотоод хяналтад</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td>шилжүүлэв.<br>2020 оны эхний хагас жилийн дүн:<br>- нийт 5 төрлийн 54 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох 91 заалтын хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд хэрэгжилтийн дүн 81.2 хувийн гүйцэтгэлтэй.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td>100 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 03 (45)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.3-р арга хэмжээ<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Ажлын хэсэг байгуулах;<br>- Саналын төсөл боловсруулж, нэгтгэх;<br>- Шаардагдах хөрөнгийн тооцоо хийж, төлөвлөх;<br>- Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;<br>- Саналыг ЗГХЭГ-т хүргүүлэх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>-</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Ажлын хэсэг байгуулагдаж, санал боловсруулсан байна;<br>- Шаардагдах хөрөнгийн тооцооллыг хийж, саналд тусгасан байна;<br>- Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнд эмхлэн байгуулагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан. Ажлын хэсэг уг хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баримтлан, “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, энэхүү бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан. Төслүүдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/1651, А-1/1953 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2 бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтот хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 12 арга хэмжээ тусгагдсан.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ТӨБЗГ-ын дангаар буюу бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнд 4 жилийн хугацаанд нийт 1,797.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс 1.9 тэрбум төгрөгийн зардлыг улсын төсвийн эх үүсвэрээс, 1,795.8 тэрбум төгрөгийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээлийн болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтийн эх үүсвэрээс зарцуулахаар батлагдсан.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилтот түвшингийн төлөвлөгөө 2021 оноос эхлэж байгаа боловч ЗГХЭГ-ын ХШҮДАГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн явцыг гаргаж, ЗГХЭГ-т мэдээлэхээр төлөвлөж байна.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | 100 хувь |

| *№ 04 (46)* | | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.4-р арга хэмжээ**<br>Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний холбогдох заалтууд, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5. |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* \| 1-р улирал \| 2-р улирал \| 3-р улирал \| 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨХШХ, ТӨБАХ |
| | *Суурь түвшин* | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2019 оны дүн, үнэлгээ – 88.0 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн". |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байх;<br>- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар. |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавьсан байна;<br>- Төлөвлөгөөнд тусгагдсан заалт буюу зорилт, арга хэмжээний хэрэгжилт - 60 хувь байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна;<br>- Төлөвлөгөөнд тусгагдсан заалт буюу зорилт, арга хэмжээний хэрэгжилт – 90 < хувь буюу "Үр дүнтэй" байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг байгууллага, нэгж, холбогдох албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ авч ажиллав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор тайлагнаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хэвшсэн байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 17 арга хэмжээний хэрэгжилтийн 2019 оны тайланг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/171 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.<br>Авлигатай тэмцэх үйл ажиллагааны 2020, 2021 оны төсөвт тодорхой хөрөнгө шаардагдана гэж үзсэн ажил, арга хэмжээг төлөвлөж, төсвийн тооцоог хийж, 2020, 2021 оны байгууллагын төсвийн төсөлд тусгуулахаар холбогдох саналаа ЗГХЭГ, СЯ-нд хүргүүлсэн боловч батлагдсан төсөвт тусгагдаагүй. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 17 арга хэмжээний 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт 88.0 хувь.<br>2020 оны тайланг хуулийн хугацаанд гаргаж, АТГ-т хүргүүлэхээр бэлтгэж байна. Урьдчилсан байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтийг 7 зорилтод хамаарах нийт 21 арга хэмжээний хүрээнд тайлагнахад 91.8 хувийн гүйцэтгэлтэй байна. ТӨБЗГ-ын чиг үүрэгт төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг хамаарахгүй болсонтой холбоотойгоор холбогдох заалтуудыг хасч тооцсон бөгөөд Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэлийн дагуу төрийн бүх шатны байгууллагад хамаарах зарим зорилт, арга хэмжээ нэмэгдэж байна.<br>2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд 11 ажил, арга хэмжээнд шаардагдах нийт 21.9 сая төгрөгийн төсвийн тооцоог хийж, байгууллагын 2021 оны төсвийн төсөлд тусгуулах арга хэмжээг авсан боловч холбогдох байгууллагаас төсөвт тусгаж батлаагүй болно. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 05 (47)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.5-р арга хэмжээ**<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, Авлигатай тэмцэх газартай хамтран сургалт зохион байгуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, 6.1.14 заалт, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.10.3 дахь зорилт, арга хэмжээ, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд авлигын эсрэг суурь мэдлэг олгох, ёс зүйн болон соён гэгээрүүлэх сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 1551 албан хаагч (ТӨБЗГ-ын болон ТӨХЭ-ийн албан хаагчид) хамрагдсан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Сургалтын хэрэгцээг тодорхойлсон байх;<br>- Сургалтанд хамрагдалт, албан хаагчийн тоогоор. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийсэн байна;<br>- ТӨБЗГ-ын болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 30< албан хаагчийг авлигын эсрэг сургалтад хамруулсан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны үндсэн дээр ТӨБЗГ-ын болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 96< албан хаагчийг авлигын эсрэг сургалтад хамруулсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | АТГ-аас 2020 онд зохион байгуулах авлигын эсрэг сургалтад хамруулах зорилгоор ТӨБЗГ-аас төлөөлөл хэрэгжүүлдэг Улаанбаатар хот, Төв аймагт (ойр орших, хамрагдах боломжтой) үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит 31 компани, үйлдвэрийн газраас авлигын эсрэг сургалтын хэрэгцээний судалгаа мэдээлэл авах ажлыг зохион байгуулсан. Нийт 15 компани, үйлдвэрийн газраас мэдээлэл, санал ирүүлсэн бөгөөд “Налайх АЗЗА” ТӨХК-иас сургалтад хамруулах шаардлагатай албан хаагч байхгүй тухай, “МИАТ” ТӨХК-иас шинээр томилогдсон болон өмнө сургалтад хамрагдаагүй 23 албан хаагчийн нэрсийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн тул давхардаж байгаа тухай мэдээлсэн байна. Мэдээлэл, судалгааны дүнд, ТӨБЗГ-ын болон харьяа 13 компани, үйлдвэрийн газрын нийт 73 албан хаагч (ТӨБЗГ-аас 2)-ийг сургалтад хамруулах захиалгыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Коронавирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөсөн сургалтын ажил хэрэгжих боломжгүй байдал үүссэн. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 30 хувь | | | | |

| *№ 06 (48)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.6-р арга хэмжээ**<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгаа явуулах, санамж, мэдээлэл хүргэх, зөвлөгөө, арга зүйгээр хангах ажлыг албан хаагчдын дунд зохион байгуулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд:<br>- давхардсан тоогоор нийт 278 мэдүүлэг гаргагч албан тушаалтан болон ЭБАТ-д арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн;<br>- харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн 43 хуулийн этгээдийн мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажил хариуцсан албан тушаалтны үйл ажиллагаанд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - ТӨБЗГ-ын албан хаагчид, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн | | | | |

| | | |
|---|---|---|
| | | оролцоотой хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйгээр хангасан байх;<br>- Сурталчилгаа, санамж, зөвлөмж хүргүүлсэн байх. |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- ТӨБЗГ-ын 31 албан хаагч, 49 хуулийн этгээдэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, санамж, зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх, зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах ажлыг хийсэн байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- ТӨБЗГ-ын 31 албан хаагч, 49 хуулийн этгээдэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, санамж, зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх, зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах ажлыг хийсэн байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | ЗГХЭГ болон АТГ-аас ирүүлсэн авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зөвлөмж, мэдээлэл, чиглэлийг харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, олон нийтэд сурталчлан таниулж, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч ажиллав. Тухайлбал, байгууллагын цахим системд холбогдох зөвлөмжүүдийг байршуулан мэдээлж, мэдээлэл, зөвлөмжийг олон хэлбэрээр түгээх арга хэмжээ авч ажиллав. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А-1/287 дугаартай албан бичгээр албан даалгавар хүргүүлсэн.<br><br>Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/13472 дугаартай албан бичгээр ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангуулахаар (мэдүүлгийн бүрдүүлэлттэй холбоотой) өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, холбогдох эрх бүхий албан хаагчдад мэдээлэл, чиглэл, зөвлөмж өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад хамруулсан.<br><br>ТӨБЗГ нь 2020 онд Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор батлагдсан 31 орон тоотойгоор ажилласан бөгөөд тэдгээрээс 29 нь мэдүүлэг гаргагч албан тушаалтан. ТӨБЗГ-ын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, мэдүүлэг мэдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн агуулга бүхий арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, холбогдох гарын авлага, материалаар хангах, мэдээлэл сурталчилгааны самбар, булан ажиллуулан мэдээлэл хүргэх арга хэмжээ аван ажилласан.<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулах тухай” ХЭГ/1205 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчил гаргах эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд анхаарч ажиллах асуудлаар байгууллагын дотоод сүлжээгээр дамжуулан нийт албан хаагчдад мэдээлэл хүргэв. Мөн дэд дарга, хэлтэс, албаны дарга, ахлах мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн гэх мэт удирдлагын шийдвэр гаргахад шууд болон шууд бус байдлаар оролцох, тэдгээрийг хэлэлцэх, бэлтгэх чиг үүрэг бүхий нийт 10 албан хаагчид Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэл, даалгаврыг тусгайлан танилцуулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Авлигын эсрэг хууль торгтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлага, чиглэлээр хангаж ажилласан. Харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 49 захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 41 ажилтан (ЭБАТ)-ыг зөвлөгөө, дэмжлэг, мэргэжил, арга зүйн удирдлагаар тухай бүр хангаж ажилласан байна. 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр АТГ-аас зохион байгуулсан “Ярилцах цаг” уулзалтад 25 ЭБАТ, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад 41 ЭБАТ-ыг тус тус хамруулан авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулав.<br><br>2020 онд шинээр томилогдсон төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын 12 ЭБАТ-д хуулийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл, зөвлөгөөг өгч, цахим системд эрх нээж өгч, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэн ажилласан байна.<br><br>Нийт дүнгээр: ТӨБЗГ-ын 31 албан хаагч, тус байгууллагад мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өмчит 49 хуулийн этгээдийн захирал, төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын нийт 41 ЭБАТ-д давхардсан тоогоор нийт 250 гаруй мэдээлэл, зөвлөгөө өгч, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллаж, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажилласан байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 07 (49)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.7-р арга хэмжээ<br>Албан хаагчдын дунд давхар ажил эрхлэлтийн судалгаа явуулж, Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалт, 18, 19 дүгээр зүйл, Авлигатай тэмцэх газрын 2017 оны 01/8836 дугаар албан бичгээр өгсөн зөвлөмжийн 6 дахь заалт, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2018 онд давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргасан, 2019 онд судалгаа хийгээгүй.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Албан хаагчдаас судалгаа авсан байх;<br>- Нэгтгэн дүгнэж, авах арга хэмжээг танилцуулсан байх:<br>- Авсан арга хэмжээний хэрэгжилт, хувиар.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>-</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- ТӨБЗГ-ын 31 албан хаагчийн дунд судалгаа хийсэн байна;<br>- Дүнг нэгтгэн боловсруулж, танилцуулсан байна;<br>- Судалгааны мөрөөр тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байна, хэрэгжилтийн хувиар.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">ЗГХЭГ болон АТГ-аас ирүүлсэн авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зөвлөмж, чиглэлийг харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, олон нийтэд сурталчлан таниулж, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч ажиллав. Тухайлбал, байгууллагын цахим системд холбогдох зөвлөмжүүдийг байршуулан мэдээлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А-1/287 дугаартай албан бичгээр албан даалгавар хүргүүлсэн.<br><br>Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/13472 дугаартай албан бичгээр ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангах тухай өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, холбогдох эрх бүхий албан хаагчдад чиглэл, зөвлөмж өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.<br><br>Монгол Улсын Засгийн газарт Авлигатай тэмцэх газрын 2017 оны 01/8836 дугаартай албан бичгээр өгсөн зөвлөмжийн ТӨБЗГ-т тусгайлан хамаарах 35, 37, 38, 39 дүгээр заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн гаргаж, А-1/918 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Давхар ажил эрхлэлтийн судалгаа хийгээгүй. Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан, хэрэгжилт дунджаар 90.0 хувь.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">70 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 08 (50)</th><th colspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="2">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.8-р арга хэмжээ<br>Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг хуулийн хугацаанд бүрдүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, тайлан мэдээг гаргаж, холбогдох байгууллагад тайлагнах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, 6.1.14 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.10.3 дахь зорилт, арга хэмжээ, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2018 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн тайланг гаргаж, 2019 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд тайлагнасан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Мэдүүлгийн бүрдүүлэлт, тайлан гаргах ажлыг хуулийн хугацаанд гүйцэтгэсэн байх;<br>- Мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээг байгууллагын тайлан мэдээнд тусгасан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- 2019 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлыг 2020 оны 2 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулах;<br>- Тайланг нэгтгэн хуулийн хугацаанд буюу 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө АТГ-т хүргүүлсэн байна;<br>- 2020 оны жилийн туршид мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, тайлан мэдээнд тусгасан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- 2020 оны тайлант хугацаанд мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, тайлан мэдээнд тусгасан байна;<br>- Мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2020 оны ХАСХОМ-ийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд шинэчлэн гаргуулах ажлыг зохион байгуулах бэлтгэл хангасан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу ТӨБЗГ-т болон түүний харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хуулийн этгээдэд мэдүүлгээ бүртгүүлдэг мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг хуулийн этгээд бүрээр шинэчлэн гаргуулах ажлыг зохион байгуулж, мэдээллийг нэгтгэн ТӨБЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А-1/59 дугаар албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. Уг жагсаалтад нэгтгэгдсэн мэдээллээр 2019 оны ХАСХОМ-ээ шинэчлэн гаргах нийт 701 албан тушаалтнаас ТӨБЗГ-т нийт 113, харьяа төрийн өмчит 43 хуулийн этгээдэд нийт 588 мэдүүлэг гаргагч 2019 оны ХАСХОМ-ээ 2020 оны 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн мэдүүлэх тооцоо гарсныг хяналтад авсан.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон тус байгууллагаас төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдийн мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн мэдүүлэх, мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2019 оны тайлан, мэдээг боловсруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж хяналт тавьж ажиллав. Нийт 694 мэдүүлэг гаргагч албан тушаалтан 2019 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд буюу 2020 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн мэдүүлж, цахим системд баталгаажуулсан бөгөөд хугацаа хоцроосон, мэдүүлэг гаргаж өгөөгүй тохиолдол гараагүй. 2020 оны 1 дүгээр сарын 1-ээс 2 дугаар сарын 15-ны хооронд мэдүүлэг гаргах нэрсийн жагсаалтаас 7 албан хаагч хасагдсан байна.<br><br>2020 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг жилийн хугацаанд тухай бүр зохион байгуулан ажиллаж, хяналт тавин хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Тайлант хугацаанд энэ чиглэлээр нийт 41 хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах эрх бүхий албан хаагчдыг удирдлага, чиглэл, арга зүйгээр хангаж ажилласан. АТГ-аас 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05/13472 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хангуулж дуусгах, холбогдох тайлан, мэдээг гаргах ажлыг бэлтгэл, зохион байгуулалтаар хангах арга хэмжээ авч байна. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | ТӨБЗГ болон түүний төлөөлөл хэрэгжүүлж байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн 2019 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайланг хянан баталгаажуулж, нэгтгэн боловсруулах ажлыг хийж, нэгдсэн дүн мэдээ, тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А-1/305 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэв. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2019 оны тайланд нэгтгэгдсэн зарим дүн мэдээг товчоолон дор танилцуулж байна:<br>– Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хамрагдсан байгууллага – 50 (ТӨБЗГ, ТӨХЭ);<br>– 2018 оны ХАСХОМ-ыг шинэчлэн мэдүүлсэн хүний тоо – 701;<br>– Тухайн жилд нэмэгдсэн мэдүүлэг гаргагчийн тоо – 176;<br>– Тухайн жилд хасагдсан мэдүүлэг гаргагчийн тоо – 183:<br>– 2019 онд ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлсэн хүний тоо – 694;<br>– Тухайн жилд их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн мэдүүлгийн тоо – 48; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | – Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдлийн тоо – 2781;<br>– Ашиг сонирхлын зөрчилтэй тухай мэдэгдлийн тоо – 4;<br>– Нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг – 230. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 09 (51)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.9-р арга хэмжээ<br>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажилтай холбоотой цахим санд холбогдох бүртгэлүүдийг хууль тогтоомжийн дагуу хийх, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ы судалгааг шинэчлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Гурав” дахь хэсгийн 3.5, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд судалгаа шинэчлэгдсэн, дахин шинэчлэх шаардлагатай.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Цахим системд бүртгэгдвэл зохих мэдүүлэг, мэдэгдлийн бүртгэлийг бүрэн бүртгэсэн байх;<br>- Харьяа ЭБАТ-ны судалгааг шинэчилсэн байх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Цахим системд бүртгэгдэх бүртгэлийг 100 хувь гүйцэтгэсэн байна;<br>- Харьяа ЭБАТ-ны судалгааг шинэчилсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Цахим системд бүртгэгдэх бүртгэлийг 100 хувь гүйцэтгэсэн байна;<br>- Харьяа ЭБАТ-ын судалгааг шинэчилсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг хариуцан зохион байгуулж ажилласан. Хууль тогтомжийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ), Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ), албан үүрэг гүйцэтгэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх асуудалтай холбоотой мэдэгдэл, тайлбар (АСМ)-ыг батлагдсан маягтын дагуу хүлээн авч, бүртгэл хөтлөх, түүнийг үндэслэн цахим системд баталгаажуулан бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн. Энэ чиглэлээр харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 41 ЭБАТ-ыг чиглүүлж ажилласан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">ТӨБЗГ-т дараах мэдүүлэг, мэдэгдэл бүртгэгдсэн. Тэдгээрт хууль тогтоомжийн дагуу цаасан болон цахим бүртгэлүүдийг хийсэн:<br>1. Албан тушаалд нэр дэвшигчдийн 94 ХАСУМ-ыг хүлээн авч бүртгэн, дүгнэлт гаргуулахаар АТГ-т хүргүүлсэн. Үүнээс:<br>ТӨБЗГ-ын албан тушаалд 30, ТӨХЭ-ийн захирлын албан тушаалд 18, ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэргэжүүлэх гишүүнээр нэр дэвшсэн этгээдийн 35 ХАСУМ (ТӨБЗГ-аас 21, яамдаас 14), ТУЗ-д хараат бус гишүүнээр нэр дэвшсэн этгээдийн 11 ХАСУМ;<br>2. Мэдүүлэг гаргачдын мэдүүлсэн 139 ХАСХОМ-ийг бүртгэн хүлээн авч, цахим системд баталгаажуулсан. Үүнээс:<br>2019 оны ХАСХОМ шинэчлэн мэдүүлсэн 110 (ТӨБЗГ-60, захирлууд-50); шинээр томилогдож 30 хоногт ХАСХОМ мэдүүлсэн 26 (ТӨБЗГ-16, захирлууд-10); их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн ХОМ 3 (захирлуудаас);<br>3. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай гаргасан 7 (ТӨБЗГ-ын албан хаагчид) АСМ-ийг хүлээн авч, цахим бүртгэлд бүртгэсэн. Үүнээс 1 АСМ-д “зөрчилтэй” тухайгаа мэдүүлсэн байна.<br>Харьяа төрийн өмчит 41 хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны судалгааг 2 удаа шинэчилж мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглан хамтран ажилласан байна.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

| *№ 10 (52)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.10-р арга хэмжээ**<br>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн бүртгэл, холбогдох баримт, материал, тайлан мэдээг хууль тогтоомжийн дагуу архивт шилжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Гурав” дахь хэсгийн 3.5, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”, Стратегийн зорилт 2.4.4, 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | - | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Холбогдох хууль тогтоомжийн дагуу 3 жилээс өмнөх баримт материалыг цэгцэлж, архивт хүлээлгэн өгсөн байх;<br>- Харьяа ЭБАТ-д чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу ТӨБЗГ-ын 3 жилээс өмнөх мэдүүлгийн бүрдүүлэлттэй холбоотой баримт материалыг цэгцэлж, архивт хүлээлгэн өгсөн байна;<br>- Харьяа ЭБАТ-д дээрх асуудлаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу ТӨБЗГ-ын 3 жилээс өмнөх мэдүүлгийн бүрдүүлэлттэй холбоотой баримт материалыг цэгцэлж, архивт хүлээлгэн өгсөн байна;<br>- Харьяа ЭБАТ-д дээрх асуудлаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу 3 жилийн өмнөх мэдүүлэгтэй холбоотой баримт материалыг архивт өгөхөөр цэгцэлж, техник ажиллагаа хийсэн. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Мэдүүлэгтэй холбоотой баримт материалыг архивт өгөхөөр цэгцэлж, техник ажиллагаа хийсэн. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 50 хувь | | | | |

| *№ 11 (53)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.11-р арга хэмжээ**<br>Газар, хэлтэс, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах, тайлагнах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэх | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам батлах тухай” 37 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны “Аргачлал, загвар батлах тухай” 47 дугаар тушаал, Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 оны газрын үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, тайлагнасан. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Батлагдсан байх;<br>- Тайлагнасан хугацаа, тоо | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:** | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - Газар жилээр, хэлтэс, албад хагас жилээр ажлаа төлөвлөж, баталгаажуулсан байна;<br>- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр хэлтэс, албад нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар тайлагнасан байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Газар жилээр, хэлтэс, албад хагас жилээр ажлаа төлөвлөн, баталгаажуулсан байна;<br>- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр, хэлтэс, албад нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар тус тус тайлагнасан байна;<br>- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТӨБЗГ-ын 2020 оны А/18 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор баталсан журам, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар баталсан аргачлал, заавар, загварын дагуу төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр ажилласан. Байгууллага, нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал, хагас жилд хяналт тавьсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр ТӨБЗГ-ын 2020 оны А/80 дугаар тушаалаар нэгжийн дарга, албан хаагчид үүрэг даалгавар өгч хэрэгжүүлсэн. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын стратеги, бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон. Ерөнхий сайдын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Энэхүү өөрчлөлттэй холбоотой албан хаагчдыг шилжүүлэх, байршуулах, албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулах, батлуулах зэрэг зохион байгуулалтын ажлууд хийгдсэнтэй холбоотой гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, албажуулах үйл ажиллагаа хүлээгдсэн. Байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажилласан. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан.<br>Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу 2020 оны 1 дүгээр сард албажуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Холбогдох холбоос: https://www.pcsp.gov.mn/f/71 . |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 12 (54)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td>Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.12-р арга хэмжээ<br>Газар, хэлтэс, албаны сарын ажлын тайланг гаргаж мэдээлэх</td></tr>
<tr><td></td><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td></td><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td></td><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ</td></tr>
<tr><td></td><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 оны зохион байгуулалтын нэгж бүр сарын тайланг гаргаж мэдээлсэн;<br>- Байгууллагын сар бүрийн ажлын тайланг нэгтгэж, Ерөнхий сайдын ажлын алба болон ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т хүргүүлсэн;<br>- Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн цахим санд тайланг оруулж, Засгийн газрын хяналтад хамруулсан.</td></tr>
<tr><td></td><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Тайланг нэгтгэж, ЗГХЭГ-т тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх;<br>- Тайлагнасан тоо.</td></tr>
<tr><td></td><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Байгууллагын сарын ажлын тайланд зохион байгуулалтын нэгжүүд тайлангаа тусгасан байх;<br>- Сарын ажлын тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нэгтгэж, Засгийн газрын хяналтад хүргүүлсэн байх, 6 удаа.</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Байгууллагын сарын ажлын тайланд зохион байгуулалтын нэгжүүд тайлангаа</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | тусгасан байх;<br>- Сарын ажлын тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нэгтгэж, Засгийн газрын хяналтад хүргүүлсэн байх, 12 удаа. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Байгууллага, нэгж бүр сарын ажлын тайланг гаргаж, хэвшсэн. Нэгжийн тайланд үндэслэн байгууллага сарын ажлын тайланг нэгтгэн боловсруулж, Ерөнхий сайдын Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлэн тайлагнасан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Байгууллагын сарын ажлын тайланг нийт 12 удаа гаргаж, ЗГХЭГ, ЕСАА-нд хүргүүлсэн. Тайлан бүрийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, өүнэлгээ, мэдээллийн нэгдсэн систем http://loginnew.unelgee.gov.mn -ний “Сарын ажлын тайлан”-ийн дэд хэсэгт байршуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 13 (55)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.13-р арга хэмжээ**<br>Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирлаар батлан, биелэлтийг сар бүр хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам батлах тухай” 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны “Аргачлал, загвар батлах тухай” 47 дугаар тушаал, Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, хэлтэс, албаны дарга нар | | | | |
| | *Суурь түвшин* | Албан хаагчдын 2019 оны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Батлагдаж, тайлагнасан хугацаа, тоо, үнэлэх | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирлаар төлөвлөн, нэгжийн даргаар батлуулсан байна;<br>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 6 удаа (сар бүр) тайлагнаж, нэгжийн дарга дүгнэн баталгаажуулсан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирлаар төлөвлөн, батлуулсан байна;<br>- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 12 удаа (сар бүр) тайлагнаж, нэгжийн дарга дүгнэн баталгаажуулсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Тайлант жилд ТӨБЗГ нь батлагдсан орон тооны дагуу 31 албан хаагчтайгаар ажилласан бөгөөд тэдгээрээс 28 албан хаагч төрийн захиргааны албан тушаал, 3 албан хаагч төрийн үйлчилгээний албан тушаалд ажилласан. Албан хаагчид Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, заавар, загварын дагуу Төрийн албан хаагч бүр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллав. Байгууллага, нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод үндэслэн албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллаж, түүний хэрэгжилтийг улирал бүр нэгжийн удирдлагад тайлагнасан. Жилийн эцэст албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх ажлыг зохион байгуулсан. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Байгууллага, нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтод үндэслэн албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллаж, түүний хэрэгжилтийг улирал бүр нэгжийн удирдлагад тайлагнасан. Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр нийт албан хаагчид хангалттай дүгнэгдсэн байна. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь | | | | |

| *№ 14 (56)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.14-р арга хэмжээ**<br>Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, холбогдох журмыг хэрэгжүүлэх | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам батлах тухай” 38 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны “Аргачлал, загвар батлах тухай” 47 дугаар тушаал, Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, хэлтэс, албаны дарга нар | | | | |
| | *Суурь түвшин* | Албан хаагчдын 2019 оны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэсэн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр дүгнэж, хянан баталгаажуулсан байх;<br>- Үнэлгээний баг байгуулах;<br>- Хууль тогтоомжийн дагуу үнэлгээ хийх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр дүгнэж, хянан баталгаажуулсан байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр дүгнэж, хянан баталгаажуулсан байна;<br>- Үнэлгээний багт дэмжлэг үзүүлэх, үнэлгээ хийх бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангасан байна;<br>- Үнэлгээний багийг холбогдох журмын дагуу байгуулсан байна;<br>- Нийт албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг хууль тогтоомжийн дагуу үнэлж баталгаажуулсан байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, заавар, загварын дагуу төрийн албан хаагчдын тухайн жилийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг ТӨБЗГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/86 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Төрийн албан хаагчдын 2020 оны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг холбогдох журам, заавар, аргачлалын дагуу зохион байгуулав. Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр нийт албан хаагчид хангалттай дүгнэгдсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/90 дугаар тушаалаар албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд нийт 38.9 сая төгрөгийг зарцуулсан. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь | | | | |

| *№ 15 (57)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.15-р арга хэмжээ**<br>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, батлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд сургалтын төлөвлөгөөнд 22 сургалт, семинар зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлсэн, хэрэгжилт 100 хувь. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлах, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Сургалтын хэрэгцээг тодорхойлсон байна;<br>- Төлөвлөгөөний төсөл боловсруулж, албан хаагчдаас санал авч тусгасан | | | | |

| | | |
|---|---|---|
| | | байна;<br>- Төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнасан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц – 40 хувь. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Төлөвлөгөөний төсөл боловсруулж, албан хаагчдаас санал авна;<br>- Төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулаж, тайлагнасан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А/107 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 2020 оны сургалтын төлөвлөгөөг газрын даргын 2020 оны А/12 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлсэн. Давхардсан тоогоор нийт 60 албан хаагчийг сургалтад хамруулсан байна.<br><br>Удирдлагын академиас зохион байгуулсан дараах сургалтад холбогдох албан хаагчийг хамруулсан:<br><br>1. “Албан хэрэг хөтлөлт” сэдэвт төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино хугацааны зайн сургалтад Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав нар;<br>2. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн (ЗУА-ны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) онлайнаар;<br>3. “Төрийн албанд ажиллах, албан тушаалын чиг үүргээ амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадвар олгох” мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн онлайнаар;<br>4. Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Хүний нөөцийн мэргэжилтэн нар онлайнаар;<br>5. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга танхим болон онлайнаар хослуулан суралцан төгссөн;<br>6. Төрийн албанд анх томилогдсон иргэний мэргэшүүлэх сургалтад Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн танхим онлайн хосолсон хэлбэрээр;<br>7. “Төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн албаны стандарт шаардлагад нийцэн ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх” сургалтад Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн онлайнаар хэлбэрээр.<br><br>Холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан дараах сургалт, семинарт холбогдох албан хаагчид хамрагдсан байна:<br><br>1. 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь” сургалтад нийт албан хаагчид;<br>2. Хүний нөөцийн институтийн “Хүний нөөцийн мэргэшүүлэх давтан сургалт”-д Захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн;<br>3. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Чадахуйн-/Мерит/ зарчмын хэрэгжилт-Хүний нөөцийн аудит” сэдэвт салбар зөвлөлийн нэгдсэн сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн;<br>4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний аргачлал, заавар” сургалтад холбогдох албан хаагчид;<br>5. Сангийн яамнаас зохион байгуулсан хүний нөөцийн системийн 2 сургалтад Ахлах нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн цахимаар;<br>6. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны уулзалт-семинар (2020.01.14), сургалт (2020.12.23)-д холбогдох албан тушаалтан.<br><br>Бусад хэлтэс, албанаас зохион байгуулах сургалтууд нь коронавирус халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас улс, нийслэлийн хэмжээнд зарласан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотой хэрэгжих боломжгүй болсон. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Давхардсан тоогоор 60 албан хаагчийг Удирдлагын академи болон бусад байгууллагаас зохион байгуулсан зорилтот сургалтуудад хамруулсан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 16 (58)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* |
|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.16-р арга хэмжээ**<br>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг зохион |

<table>
<tr><td></td><td colspan="6">байгуулах, тайлагнах</td></tr>
<tr><td></td><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд давхардсан тоогоор 106 албан хаагчийн нийгмийн баталгаа хангах арга хэмжээнд 82.5 сая төгрөгийн тусламж, дэмжлэг олгосон.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байх;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Төлөвлөгөөний төсөл боловсруулж, баталсан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц – 50 хувь байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Төлөвлөгөөний төсөл боловсруулж, албан хаагчдаас санал авна;<br>- Төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь байна.</td></tr>
<tr><td>Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Төрийн албаны тухай хууль болон ТӨБЗГ-ын даргын 2017 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв:<br><br>1.“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам”-ын дагуу газрын даргын тушаалаар ар гэрт нь гачигдал гарсан 5 албан хаагчид нийт 1000000 төгрөгийн тусламж олгосон.<br><br>2.Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид болон тус газрын ахмад настнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, цаашид уг ажлыг жил тогтмол зохион байгуулж хамтран ажиллах тухай хүсэлтийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирал нарт тус тус албан бичгээр хүргүүлсэн. Улмаар албан хаагчид, байгууллагын ахмад настнууд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт байнгын үзлэг шинжилгээнд хамрагдах боломж нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллав. Энэ хүрээнд тус эмнэлгийн бүртгэл-мэдээллийн санд холбогдох мэдээлэл судалгааг оруулж, тайлант оны 04 дүгээр сараас үзлэг шинжилгээнд хамрагдах боломжтой болсон.<br><br>3.2020 оны Цагаан сарын баярыг тохиолдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяалалд бүртгэлтэй 28 ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд тус бүрт 100000 төгрөгийн тусламж, дэмжлэг олгосон бөгөөд нийт 2,800,000.00 төгрөгийг зарцуулсан.<br><br>4.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт улс, нийслэлийн хэмжээнд хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан байгууллагад гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулах чиг үүрэг бүхий Шуурхай штабыг газрын даргын тушаалаар байгуулж, холбогдох шуурхай арга хэмжээг аван ажилласан. Энэ хүрээнд нийт албан хаагчдад ариутгал, халдваргүйжүүлэлтийн хэрэгсэл, дархлаажуулалтын бүтээгдэхүүн зэргээр хангаж, Засгийн газар, Улсын Онцгой комисс, бусад мэргэжлийн байгууллага, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газраас өөрсдийн чиг үүргийн дагуу ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг цаг тухайд нь мөрдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухайн цаг хугацаанд албан хаагчдыг хуваарийн дагуу ажиллуулж, гэрээсээ ажиллах боломж нөхцлийг бий болгох арга хэмжээ авч ажилласан. Энэ хүрээнд 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдыг гэрээсээ цахимаар ажиллуулах арга хэмжээ авсан.<br><br>5.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр дотоод журамд заасны дагуу албан хаагчдын 0-16 насны хүүхдэд бэлэг дурсгалын зүйл гардуулж, ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/39 дүгээр тушаалаар нийт 2,600,000.00 төгрөгийг зарцуулсан.<br><br>6.Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу холбогдох судалгааны үндсэн дээр 9 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон хувь хэмжээг ахиулан олгох арга хэмжээ авсан.<br><br>7.Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | захиргааны албан тушаалын зэрэг, дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу холбогдох судалгаанд үндэслэн 6 албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгож, Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд мэдээллийг оруулан албан хаагчид танилцуулсан.<br>8.Сангийн сайдын 2020 оны 72 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/44 дүгээр тушаалаар Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн 3 албан хаагчид Санхүүгийн улсын ахлах байцаагч, 3 албан хаагчид санхүүгийн улсын байцаагчийн эрх олгосныг үндэслэн албан тушаалын зэрэглэлийг ахиулан цалинг шинэчлэн тогтоосон.<br>9.Газрын даргын 2020 оны А/17 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэр тогтоолгон Төрийн албанаас 2020 онд чөлөөлөгдсөн 4 албан хаагчид хүндэтгэл үзүүлж, нийт 1,870,000.00 төгрөг зарцуулсан.<br>10.Тайлант хугацаанд Төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор 1 албан хаагч, "Нийгмийн даатгалын хүндэт тэмдэг"-ээр 1 албан хаагч шагнагдсан.<br>11.Коронавируст халдвар /KOVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан ипотекийн зээлд байгууллагын албан хаагчдаас хамруулах тухай хүсэлтийг Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсний дүнд нэр бүхий 10 албан хаагч "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-д холбогдох материалаа өгч ипотекийн зээлд хамрагдахаар батламж авсан.<br>12.Ажлын зайлшгүй шаардлагаар 2020 оны ээлжийн амралтаа биеэр эдлээгүй албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу нийт 9.7 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар олгосон.<br>13.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/90 дугаар тушаалаар албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд нийт 38.9 сая төгрөгийг зарцуулсан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" тухайн жилд зохих хэмжээнд хэрэгжиж, дээр дурдсан үр дүн гарсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 17 (59)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.17-р арга хэмжээ**<br>Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх, баяжилт хийх, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөний болон бусад мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж, тайлагнах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн дарга нарын 2019 оны 34/31 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам", Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 оны хэрэгжилт – 100 хувь. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийн хувь;<br>- Төрийн албан хаагчийн хөдөлгөөнтэй холбоотой ажил хүлээлцсэн баримтыг хөтөлсөн байх;<br>- Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний мэдээ, тайланг хуулийн хугацаанд тайлагнасан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангагдаж, баяжилт хийгдсэн байна;<br>- Төрийн албан хаагчийн хөдөлгөөнтэй холбоотой ажил хүлээлцсэн баримтыг хөтөлсөн байна;<br>- Мэдээ, тайланг Төрийн албаны зөвлөлд тогтоосон хугацаанд тайлагнасан байна, тухай бүрд. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангагдаж, баяжилт хийгдсэн байна; | | | | |

| | | |
|---|---|---|
| | | - Төрийн албан хаагчийн хөдөлгөөнтэй холбоотой ажил хүлээлцсэн баримтыг хөтөлсөн байна;<br>- Мэдээ, тайланг Төрийн албаны зөвлөлд тогтоосон хугацаанд тайлагнасан байна, тухай бүрд. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж, шинээр байгуулагдсан Төрийн Худалдан авах ажиллагааны газарт холбогдох чиг үүрэг шилжин Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаар 31 байхаар тогтоосон. Үүнтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт чиг үүрэг нь шилжсэн 37 албан хаагчийн хувийн хэрэг, мэдээллийг шинэчлэн хүлээлгэн өгсөн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 31 албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу хувийн хэргийн бүрдлийг хангуулах арга хэмжээ авч, хувийн хэрэг тус бүрээр кодлон жагсаалт гаргаж, баяжилт хийсэн.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга нарын хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу 1 албан хаагч (ЗУА-ны дарга асан)-ийг хүсэлтийн дагуу өөр төрийн байгууллагад шилжүүлж, өөр төрийн байгууллагад ажиллаж байсан 3 албан хаагчаас шилжин ажиллах хүсэлт гаргасны дагуу судлан үзэж, журмын дагуу шилжүүлэн авч ажиллуулж байна. Байгууллагын даргын тушаал гарч, өөр байгууллагад шилжсэн болон ТӨБЗГ-т өөр байгууллагаас шилжин ажиллахаар болсон нийт 4 албан хаагчид холбогдох тушаалууд, баримт материалыг танилцуулж, шилжиж ирсэн албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийсэн. Байгууллагын дотоод бүтцийн хэлтэс хооронд сэлгэн ажиллуулах тухай Газрын даргын тушаал гарсан 2 албан хаагчид томилогдсон тушаал болон албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, холбогдох журмын дагуу хувийн хэргийн баяжилтыг хийв.<br>Төрийн албаны зөвлөл, Сангийн яамны хамтран шинээр нэвтрүүлж байгаа Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн сургалтад байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн, ерөнхий нягтлан нар хамрагдаж, тус системд албан хаагчдын холбогдох мэдээллийг тухай бүр оруулж байна. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайлан, мэдээг холбогдох цахим системд оруулан тайлагнав. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 18 (60)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.18-р арга хэмжээ**<br>Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, Төрийн албаны зөвлөлөөр хянуулах, батлах | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, Стратегийн зорилт 2.4.4. | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, Ажлын хэсэг | | | | |
| | *Суурь түвшин* | Ажлын байрны тодорхойлолт 2016 онд батлагдсан. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэн, байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Албан тушаалын тодорхойлолт батлагдсан байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээг хийсэн байна;<br>- Албан тушаалын тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулсан байна;<br>- Албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-өөр хянуулах, зөвшөөрөл авсан байна;<br>- Баталж, мөрдүүлсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-өөр хянуулах, зөвшөөрөл авч, баталсан байна;<br>- Батлагдсан албан тушаалын тодорхойлтыг мөрдүүлсэн байна. | | | | |
| Арга | *Хэрэгжилт* | Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүтэц, | | | | |

| | | |
|---|---|---|
| хэмжээний хэрэгжилт | | зохион байгуулалт 2 удаа өөрчлөгдөж, Ерөнхий сайдын захирамжаар 2020 оны 06, 79 дүгээр захирамжаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгууллалтын бүтэц" тухай бүр батлагдсан.<br>1.Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг хамаарахгүй болж, ТӨБЗГ-ын орон тоог шинээр "31" байхаар тогтоосон. Засгийн газрын уг тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамж гарсантай холбоотой Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан тушаалын тодорхойлолт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Газрын даргын 2020 оны А/08, А/18 дугаар тушаалаар байгуулж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан холбогдох материалуудын хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулж, батлах зөвшөөрөл авсан. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 102 дугаар тогтоолоор албан тушаалын 14 тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу Газрын даргын 2020 оны А/28 дугаар тушаалаар удирдах болон гүйцэтгэх 14 албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 6.2 дахь хэсэгт заасны дагуу албан хаагч тус бүрт албан тушаалын тодорхойлолтыг танилцуулан хувийн хэрэгт баяжилт хийсэн.<br>2.Засгийн газрын 2020 оны 144 тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаар "55" байхаар шинэчлэн тогтоосонтой холбоотой Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар тус байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэн. Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг Газрын даргын А/75 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шинээр 5, шинэчлэн 8, өөрчлөлт оруулах 7 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан. Удирдах 3, гүйцэтгэх 17, нийт 20 албан тушаалын тодорхойлолтыг хянуулж, батлах зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох судалгаа, шинжилгээ, үндэслэл бүхий баримт материалын хамт Төрийн албан зөвлөлд хүргүүлсэн. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Ерөнхий сайдын 2020 оны 06, 79 дүгээр захирамжаар "ТӨБЗГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц" тайлант жилд 2 удаа шинэчлэн өөрчлөгдсөнтэй холбоотой албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн батлах зөвшөөрөл авах ажлыг 2 удаа зохион байгуулан ажилласан. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 102 дугаар тогтоолоор олгосон зөвшөөрлийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А/28 дугаар тушаалаар 27 орон тоонд ашиглагдах төрийн захиргааны албан тушаалын 14 тодорхойлолтыг батлан мөрдүүлсэн. Мөн төрийн үйлчилгээний 3 албан тушаалын тодорхойлолт (ахлах нягтлан бодогч, нярав, архив, бичиг хэргийн ажилтан)-ыг боловсруулж, ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлан мөрдүүлсэн байна.<br>Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тоо "31" байсныг "55" болгон 24 орон тоогоор нэмэгдүүлсэн. Үүнтэй холбоотой ТӨБЗГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/72 дугаар тушаалаар ТӨБЗГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг баталсан. Холбогдох судалгаа, шинжилгээ хийж, шаардлагатай албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулав. Төрийн захиргааны удирдах 3, гүйцэтгэх 17, нийт 20 албан тушаалын тодорхойлолтын төслийг хянуулж, батлах зөвшөөрөл авахаар холбогдох материалыг бэлтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна. 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний 9 албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлсэн. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 19 (61)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.19-р арга хэмжээ**<br>Албан хаагчдын дунд ёс зүйн хэм хэмжээг сахиулах болон хууль тогтоомж зөрчиж аливаа зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |

| | | |
|---|---|---|
| үзүүлэлт | *Хариуцах нэгж* | ЗУХ, Ёс зүйн зөвлөл, Хэлтэс, албаны дарга нар |
| | *Суурь түвшин* | - 2019 онд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулсан;<br>- Зөрчил, дутагдал гаргасан 2 албан хаагчид хариуцлага тооцсон;<br>- “Ёс зүйн зөвлөл”-ийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар байгуулсан;<br>- Байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн. |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Ёс зүйн зөвлөлийг өөрчлөн байгуулах;<br>- Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, батлах;<br>- Холбогдох дүрэм, журмын хэрэгжилт, хувиар. |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулж, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан баталсан байна;<br>- Ёс зүйн зөвлөлийг өөрчлөн байгуулж ажиллуулсан байна;<br>- Холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулсан байна;<br>- Хэрэгжилтийг тайлагнасан байна, хэрэгжилт – 90< хувь байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Холбогдох дүрэм, журмыг албан хаагчдад таниулах, сурталчлах, зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна;<br>- Хэрэгжилтийг тайлагнасан байна, хэрэгжилт – 90< хувь байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нийт албан хаагчаас санал авч, байгууллагын албан хаагчдын хурлаар хэлэлцүүлэн “Ёс зүйн зөвлөл”-ийг Газрын даргын А/10 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, мэдээллийг дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийн ажиллах журмын төсөлд нэгжүүдээс санал авч, Газрын даргын 2020 оны А/15 дугаар тушаалаар журмыг баталсан. Батлагдсан журмыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулсан бөгөөд холбогдох мэдээ, тайланг улирал бүр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажилласан.<br>Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор “Ёс зүйн зөвлөл”-ийг 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулж, түүний ажиллах журмыг батлан мөрдүүлсэн байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргасан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

<table>
<tr><th>№ 20 (62)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.20-р арга хэмжээ<br>Төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цалингийн шатлал нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон бусад журам, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="5">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд:<br>- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 7 албан хаагч хамрагдсан;<br>- Албан тушаалын зэрэг дэвийг холбогдох шийдвэрийн дагуу нийт 33 албан хаагчид шинээр болон шинэчлэн олгосон.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Судалгаа гаргасан байх;<br>- Нэмэгдэл, зэрэг дэв олгогдсон болон шатлал нэмэгдсэн албан хаагчийн тоо;<br>- Хууль тогтоомжид нийцсэн үндэслэлтэй байх.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Судалгаа гаргасан байна;<br>- Хууль тогтоомжид заасан үндэслэл бүхий болзол шаардлага хангасан албан хаагчийг хамруулсан байна;<br>- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна, хэрэгжилт - 100 хувь байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ажилласан жилийн судалгааг гарган байгууллагын удирдлагуудад танилцуулан Газрын даргын Б/22, Б/69 дугаар тушаалаар 9 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 6 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон ахиулан олгосон. Төрийн өмчийн бүртгэлийн хэлтсийн 3 албан хаагчид Санхүүгийн Улсын ахлах байцаагч, 3 албан хаагчид санхүүгийн улсын байцаагчийн эрхийг Сангийн сайдын 2020 оны 72 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/44 дүгээр тушаалуудаар олгосныг үндэслэн албан тушаалын зэрэглэлийг хууль тогтоомжийн дагуу ахиулан олгосон. Эдгээр шийдвэрийг албан хаагч тус бүрт танилцуулан хувийн хэрэгт баяжилт хийж, холбогдох мэдээллийн өөрчлөлтийг хүний нөөцийн системд оруулан баталгаажуулсан. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | |
| | *Хүрсэн түвшин* | 2020 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу судалгаанд үндэслэн 9 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 6 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон ахиулан, 6 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг хууль тогтоомжид нийцүүлэн ахиулах арга хэмжээ авч, Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж шийдвэрлэсэн байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 21 (63)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.21-р арга хэмжээ**<br>Төрийн албаны зөвлөлийн хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Засгийн газрын 1996 оны "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" 66 дугаар тогтоол, Стратегийн зорилт 2.4.4. | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | .... мянган төгрөг | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ | | | |
| | *Суурь түвшин* | - 2019 онд 12 дугаар сард Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалт хийж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах;<br>- Үр дүнг хугацаанд нь тайлагнасан байх. | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байна;<br>- Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн талаар дурдсан хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд тайлагнасан байна. | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна. | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | 2019 оны 12 дугаар сард Төрийн албаны зөвлөлөөс хийсэн хяналт шалгалтын мөрөөр Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 30 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллахыг даалгасны дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажилласан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, зөрчил, дутагдлыг арилгасан талаар биелэлтийн тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 30 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг биелэлтийг хангаж, алдаа дутагдлыг арилгасан талаарх тайлан мэдээллийг заасан хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь | | | |

<table>
<tr><th>№ 22 (64)</th><th colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.22-р арга хэмжээ<br>Албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн уялдаа:</td><td colspan="5">Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">.... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 онд газрын даргын А/49 дүгээр тушаалаар “Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комисс”-ыг байгуулан ажиллуулсан;<br>- 2019 оны “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явц - 90 хувийн гүйцэтгэлтэй.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- “Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комисс”-ыг шинэчлэн байгуулах;<br>- Олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Комиссыг шинэчлэн байгуулсан байна;<br>- Албан хаагчдын дунд зохион байгуулах олон нийтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Албан хаагчдын дунд зохион байгуулах олон нийтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна;<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Байгууллагын албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах комиссыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/32 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.<br>Олон нийтийн арга хэмжээ зохион байгулах комиссоос тайлант хугацаанд зарим тэмдэглэлт өдөр, баяр ёслолын үеэр зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хүндэтгэл үзүүлэх хэлбэрээр зохион байгуулсан. Ингэхдээ коронавирусын халдварын цар тахалтай холбоотойгоор нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүйгээр, төсөв зардлыг хэмнэх бодлого барин ажилласан.<br>ТӨБЗГ-ын дотоод журамд заасны дагуу дараах баяр ёслолын өрүүдэд ахмад, настнуудад хүндэтгэл үзүүлж, албан хаагчдын 0-16 насны хүүхдэд бэлэг дурсгалын зүйл бэлтгэн хүргүүлсэн байна. Үүнд:<br>Цагаан сарын баяраар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяалалд бүртгэлтэй 28 ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд тус бүрт 100000 төгрөгийн тусламж, дэмжлэг олгож, нийт 2,800,000.00 төгрөгийг зарцуулсан.<br>Мөн ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/17 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэр тогтоолгон төрийн албанаас 2020 онд чөлөөлөгдсөн 4 албан хаагчид хүндэтгэл үзүүлж, нийт 1,870,000.00 төгрөг зарцуулсан.<br>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын 0-16 насны хүүхдэд бэлэг дурсгалын зүйл гардуулж, нийт 2,600,000.00 төгрөгийг зарцуулсан.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Коронавирусын халдварын цар тахалтай холбоотойгоор нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүйгээр, төсөв зардлыг хэмнэх бодлого барин ажилласан. Иймээс зайлшгүй шаардлагатай дээр дурдсан 3 арга хэмжээг хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах хэлбэрээр зохион байгуулж, тодорхой төсөв зарцуулсан. Нийт 7,270,000.0 төгрөгийг зарцуулсан байна.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><th>№ 23 (65)</th><th colspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</th></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="2">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.23-р арга хэмжээ<br>Газрын хуралдаан, Даргын Зөвлөлийн хурал, бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн</td><td>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийн 4 дүгээр бүлэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>уялдаа:</td><td colspan="5">журам”-ын 2.2, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлийн ажиллах журам”, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, ТӨУЗХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">2019 онд:<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”-ыг 27 удаа зохион байгуулж, 713 асуудлыг хэлэлцүүлсэн;<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл”-ийг 7 удаа хуралдуулж, 16 асуудлыг хэлэлцүүлсэн.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">Зохион байгуулагдсан хуралдаан, хэлэлцсэн асуудлын тоо</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”-ы төлөвлөгөө, дэгийн дагуу тухай бүр зохион байгуулсан байна;<br>- Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын тоо, төрлийн судалгаа гарсан байна;<br>- Хуралдааны шийдвэрийн ил тод байдлыг хангасан байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан”-ыг төлөвлөгөө, дэгийн дагуу тухай бүр зохион байгуулсан байна;<br>- Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын тоо, төрлийн судалгаа гарсан байна;<br>- Хуралдааны шийдвэрийн ил тод байдлыг хангасан байна;<br>- Хурлын шийдвэр, холбогдох материалыг архивт шилжүүлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын хуралдаан (Засгийн газраас томилогдсон орон тооны бус гишүүд бүхий бүрэлдэхүүн хуралдаж, төрийн өмчийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг), Даргын зөвлөл, удирдлагын шуурхай хурал, нийт албан хаагчдын хурлын зохион байгуулалтыг ханган ажиллаж, тухайн хуралдаанаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар зэргийг албажуулан хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан ажилласан байна. Үүнд:<br>1.ТӨБЗГ-ын хуралдааны дэгийг ТӨБЗГ-ын 2020 оны 53 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, мөрдүүлсэн. ТӨБЗГ-ын хуралдааныг дэгийн дагуу нийт 21 удаа зохион байгуулж, төрийн өмчийн асуудлаар нийт 819 асуудал хэлэлцэж, нийт 806 шийдвэр гаргасны 780 нь тогтоол, 26 нь тэмдэглэл байна.<br>ТӨБЗГ-ын хуралдаанаас гаргасан 806 шийдвэрийг агуулгаар нь авч үзвэл,<br>- эрх зүйн акт – 8;<br>- хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц – 9;<br>- эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин – 93;<br>- хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх – 11;<br>- төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилох, чөлөөлөх – 29;<br>- хуулийн этгээдийн бусад асуудлаар – 42;<br>- өмч хувьчлал – 9;<br>- хөрөнгийн шилжилт хөдөлгөөн – 582;<br>- хяналт шалгалт – 23.<br>ТӨБЗГ-ын хуралдааны шийдвэрийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулж, хяналтын тавин ажиллав. Нийт шийдвэрийн 72.2 хувь нь өмч хөрөнгийн бүртгэл, шилжилт, хөдөлгөөний зохицуулалтын, 11.5 хувь төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, биелэлтийг батлах асуудлаар, 5.2 хувь нь төрийн өмчит хуулийн этгээдэд удирдамж өгөх болон бусад асуудлаар гарсан байна.<br>2.ТӨБЗГ нь даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг А/51, 59 дүгээр тушаалаар тус тус өөрчлөлт оруулан баталж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Даргын зөвлөл тайланд хугацаанд 2 удаа хуралдаж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, мэдээг хэлэлцэн дүнг баталгаажуулан хэлэлцсэн асуудалтай холбоотой хурлын тэмдэглэлээр нэгжийн дарга нар, албан хаагчдад үүрэг даалгавар өгч ажилласан байна. Даргны зөвлөлийн зэрэгцээ удирдах ажилтны шуурхай хуралдааныг 17 удаа зохион байгуулж, хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийг нэгж, албан хаагчид хэрэгжүүлэн, биелэлтийг удирдлагад танилцуулан ажиллав.<br>3.Нийт албан хаагчдын хурал, цуглааныг тайлант хугацаанд нийт 8 удаа зохион байгуулж, цаг үеийн асуудлаар мэдээлэл сонсч, шуурхай авах арга хэмжээ, шаардлагатай мэдээллийг танилцуулан үүрэг, чиглэл өгч ажилласан байна.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">ТӨБЗГ-ын хуралдааныг 2020 оны 53 дугаар тогтоолоор баталсан дэгийн дагуу нийт 21 удаа зохион байгуулж, төрийн өмчийн асуудлаар 819 асуудал хэлэлцэж, 806 шийдвэр гаргасны 780 нь тогтоол, 26 нь тэмдэглэл байна. Тогтоолын хэрэгжилтэд хяналтад тавин, ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | Даргын зөвлөлийн хуралдааныг 2 удаа, удирдлагын шуурхай хуралдааныг 17 удаа зохион байгуулж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн явц, дүнг хэлэлцэж, цаг үеийн асуудлаар шуурхай арга хэмжээ аван, ажлын явцыг эрчимжүүлж ажилласан байна. Нийт албан хаагчдын хурал, цуглааныг 8 удаа зохион байгуулж, шуурхай мэдээлэл, үүрэг, чиглэл өгч ажилласан. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 24 (66)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.24-р арга хэмжээ**<br>Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангаж ажиллах, албан бичгийн шийдвэрлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалт, Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар”, Стратегийн зорилт 2.4.4. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, Хэлтэс, албаны дарга нар | | | | |
| | *Суурь түвшин* | Албан бичгийн эргэлтийн тоо: ирсэн 6222, явуулсан 4282 бичиг, 3758 хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 90.0% (2017, 2018, 2019 оны үзүүлэлтийн дунджаар). | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Байгууллага, хэлтэс, албаны албан бичиг хэргийн эргэлтийн тайлан мэдээг гаргаж, дүгнэлт хийсэн байх. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Байгууллага, хэлтэс, албаны албан бичиг хэргийн эргэлтийн тайлан мэдээг гаргаж, дүгнэлт хийн мэдээлсэн байна;<br>- Хариутай бичгийн шийдвэрлэлтийг 95< хувьд хүргэсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Албан бичиг хэргийн эргэлтийн тайлан мэдээг гаргаж, дүгнэлт хийн мэдээлсэн байна;<br>- Хариутай бичгийн шийдвэрлэлтийг 95< хувьд хүргэсэн байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Шаардлага хангасан бичиг баримтыг хүлээн авч, бүртгэн удирдлагад танилцуулах, удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтэс, мэргэжилтэнд шилжүүлэн хэрэгжилтийг хангуулж ажилласан.<br>Бичиг хэргийн эргэлт:<br>- ирсэн бичгийн тоо – 4177;<br>- хариутай бичиг 2539: шийдвэрлэсэн 2356, хяналтанд 183 (он дамжсан);<br>- хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь – 92.79 хувь;<br>- хариугүй бичиг – 1638.<br>ТӨБЗГ-аас явуулж буй албан бичгийн төслийг албажуулах, стандартын бүрдэл, гарын үсэг, тамга тэмдгийг шалгах, дугаарыг бүртгэн олгох, өдөр тутамд бүртгэл үйлдэн шууданд хүлээлгэн өгөх ажиллагааг холбогдох заавар, журмын дагуу гүйцэтгэн ажилласан. Тайлант хугацаанд нийт 2264 албан бичгийг 6270 бусад байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн байна. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь – 92.79 хувь байна. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь | | | | |

| *№ 25 (67)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | |
|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.25-р арга хэмжээ**<br>Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчдаас баримт, материалыг архивт хүлээн авах ажлыг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, байгууллагын архивын баяжилт хийх | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалт, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар”, Стратегийн зорилт 2.4.4. |

<table>
<tr><td rowspan="6">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, хэлтэс, албад</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нийт 55 хэрэг хөтлөгдөхөөр шийдвэрлэгдэн батлагдсан;<br>- 2019 онд зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т 83.4 хувь буюу “В” үнэлгээтэй дүгнэгдсэн.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн баталсан байх;<br>- Баримт бичгийг нягтлан шалгах комисс (ББНШК)-ыг байгуулсан байх:<br>- Хэлтэс, алба, албан хаагчдаас хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу архивын баримт материалыг архивт хүлээн авсан байх;<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын хадгаламжийн нэгжийг бүрдүүлж, данс, бүртгэл хөтөлсөн байх.</td></tr>
<tr><td>Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн баталж, ББНШК-ыг байгуулсан байна;<br>- Хэлтэс, алба, албан хаагчдаас 2019 оны баримт, материалыг архивт хүлээн авсан байна, 1 дүгээр улиралд;<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн данс, бүртгэл хөтөлж, дүн мэдээг тайлагнасан байна.<br><br>Жилийн эцэст:<br>- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, алба, албан хаагчдаас баримт, материалыг архивт хүлээн авсан байна;<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн данс, бүртгэл хөтөлж, стандартыг хэрэгжүүлэн, дүн мэдээг тайлагнасан байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу ТӨБЗГ-ын 2020 оны А/47 дугаар тушаалаар Баримт бичиг нягтлан шалгах комиссыг байгуулж, уг комиссын дүрмийг, А/48 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивын дүрэм”-ийг тус тус боловсруулан баталж мөрдүүлэв. Түүнчлэн архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, заавар, стандартыг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-ын даргын А/52 дугаар тушаалаар зохион байгуулалтын нэгжийн индекс, А/57 дугаар тушаалаар тус байгууллагад хэрэглэгдэх хэвлэмэл хуудасны нэр төрөл, тэдгээрийн индексийг тус тус боловсруулан баталж, мөрдүүлэв.<br><br>Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын 1 дүгээр хурлыг хуралдуулж, хурлаар байгууллагын 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, Архивын баримтад тооллого хийх удирдамжийг тус тус батлан, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А/53 дугаар тушаал гарсантай холбогдуулан архивын баримтыг эрэн сурвалжлах, архивын баримт материалд үзлэг, тооллого хийх ажлыг гүйцэтгэв.<br><br>“Байгууллагын архивын үндсэн зааврын 10.4.1, 10.4.2.-т заасны дагуу Архивын ажлыг өндөр насны чөлөөнд гарсан ажилтнаас хүлээн авах ажлыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласан. Энэ хүрээнд 2019 оны 600 баримт задгай хүлээн авсан байсныг зааврын дагуу техник боловсруулалт хийж, үдэж хавтаслан данс бүртгэлд тусгасан. 2016-2019 оны баримтуудыг данс бүртгэлтэй нь тулгалт хийсэн.<br><br>2020 оны 01 сараас 10 сар хүртэлх ТӨБЗГ-т ирсэн бичиг, ТӨБЗГ-аас бусад байгууллага, иргэн, хуулийн этгээдэд явуулсан бичгийг эмхлэн цэгцэлж, техник боловсруулалт хийн үдэж хавтаслан архивын хадгаламжийн нэгжийн баяжилтыг холбогдох заавар, журам, аргачлал, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.<br><br>Байгуулага, иргэд, албан хаагчдад архивын үйлчилгээ үзүүлэх, лавлагаа өгөх хүрээнд 124 баримтыг ашиглалтад, 122 баримтын хуулбарыг тус тус бүртгэлээр олгож, 327 хуудас баримтад хуулбар үнэн тэмдэглэгээ хийж үйлчилсэн.<br>Архивын ажлын талаарх дүн мэдээ, тайланг сар бүр тайлагнан хэлтэс, байгууллагын тайлан мэдээнд тусган мэдээлсэн.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">- Архивын баримтын хадгалалт хамгаалалт сайжирсан;<br>- Лавлагаа үйлчилгээнд гаргах боломжтой болсон;<br>- Баримт, хадгаламжийн нэгжийн тооллого, дансны тулгалт хийгдсэн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">100 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><td>№ 26 (68)</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.26-р арга хэмжээ<br>2019 онд зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн үндэслэл:</td><td colspan="5">Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны “Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай” 106 дугаар тогтоол, Архивын ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн 2019 оны 01-37 дугаар дүгнэлт, Стратегийн зорилт 2.4.4,</td></tr>
<tr><td rowspan="7">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ЗУХ, хэлтэс, албад</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">- 2019 онд зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т 83.4 хувь буюу “В” үнэлгээтэй дүгнэгдсэн.<br>- Улсын байцаагчийн дүгнэлтийг хүлээн авсан.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="5">- Улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээг судлан тодорхойлсон байх;<br>- Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах асуудлыг холбогдох хэлтэс, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байх.</td></tr>
<tr><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td colspan="5">Эхний хагас жилд:<br>- Улсын үзлэгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</td></tr>
<tr><td colspan="5">Жилийн эцэст:<br>- Улсын үзлэгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td colspan="5">Архивын улсын үзлэгийн дүнгийн мөрөөр хийх ажлын хүрээнд улсын байцаагчийн дүгнэлтэд дурдагдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллав. Үүнд:<br><br>Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 7.3-д заасны дагуу түүхчилсэн лавлах үйлдэж байна.<br><br>Архивын өрөөнд хадгаламжийн нэгжээс өөр эд зүйлс байрлуулахгүй байх, Хууль зүйн сайдын 2015 оны А/224 дүгээр тушаалаар баталсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-д нийцүүлэх арга хэмжээ авч ажиллав.<br><br>“Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 10.4.-т заасан “Архивын ажилтан /эрхлэгч/ ажлаас чөлөөлөгдөх үед архивын баримт хүлээн авах, шилжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, өндөр насны тэтгэвэрт 2020 оноос гарсан архивын ажилтнаас техник боловсруулалт хийгдсэн, үдэж хавтаслан архивд хүлээлгэж өгөхөд бэлэн болсон баримтыг хүлээн авах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллав. Заавар, журамд заасны дагуу ажил хүлээлцэх комиссын ажиллаж, архивын ажлыг хүлээлцүүлэв.<br><br>Албан хаагчдаас хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу архивт баримт хүлээн авахдаа “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 3.3, 3.4 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу бүрдүүлэлт хийгдсэн дараа хүлээн авч байна.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td colspan="5"></td></tr>
<tr><td>Хүрсэн түвшин</td><td colspan="5">Байгууллагын архивын хадгаламжийн нэгжээс лавлагаа мэдээлэл олгох болон ашиглалтад гаргах үйлчилгээ үзүүлэхэд баримт материалыг бэлдсэн.<br>Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээг авч, хэрэгжүүлсэн.</td></tr>
<tr><td colspan="2">Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</td><td colspan="5">70 хувь</td></tr>
</table>

<table>
<tr><td>№ 27 (69)</td><td colspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="2">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.27-р арга хэмжээ<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, судлан шийдвэрлэж, хариу өгөх, тайлагнах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн үндэслэл:</td><td>Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Стратегийн зорилт 2.4.4.</td></tr>
</table>

| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
|---|---|---|---|---|---|---|
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ЗУХ, хэлтэс, албаны дарга нар | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 онд:<br>- 209 өргөдөл, гомдол хүлээн авсан;<br>- шийдвэрлэлт 86 хувь;<br>- тайлагналт, улирал бүр (2017, 2018, 2019 оны үзүүлэлтийн дундаж). | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Шийдвэрлэлтийн хувь;<br>- Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байх;<br>- Тайлагналтын хугацаа. | | | | |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- Хүлээн авсан өргөдөл, гомдол шийдвэрлэлт 95.0< хувь байна;<br>- Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна;<br>- Улирал бүрийн дараа сарын эхний 7 хоногт тайлагнаж, нээлттэй мэдээлсэн байна. | | | | |
| | | **Жилийн эцэст:**<br>- Хүлээн авсан өргөдөл, гомдол шийдвэрлэлт 95.0< байна;<br>- Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна;<br>- Улирал бүрийн дараа сарын эхний 7 хоногт тайлагнаж, нээлттэй мэдээлсэн байна. | | | | |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | 2020 онд тус байгууллага нийт 62 өргөдөл, 8 гомдол, 69 хүсэлт, 1 мэдээлэл, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв “11-11 төв”-өөс 1, нийт 141 өргөдөл, гомдол хүлээн авсан байна.<br>Ирсэн өргөдөл, гомдлыг илгээгчээр нь ангилан үзвэл иргэнээс 83 буюу 62.41%, ТӨБЗГ-ын албан хаагчдаас 30 буюу 22.56%, бусад байгууллага, хамт олноос 12 буюу 8.57% тус тус ирүүлсэн байна.<br>Тайлант хугацаанд, 141 өргөдөл, гомдлын 121-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн, 20 нь хяналтад байгаа бөгөөд тэдгээр нь он дамжиж шийдвэрлэгдэхээр байна. Шийдвэрлэлт - 85.81%.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг сар бүр гаргаж, хяналт тавин ажилласан байна. | | | | |
| | *Зарцуулсан хөрөнгө* | | | | | |
| | *Хүрсэн түвшин* | Шийдвэрлэлтийн хувь – 85.81 хувь. | | | | |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь. | | | | |

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.1.-ийн үр дүн:** Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангасан байна.

| № | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин / Хүрсэн түвшин / Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өмнөх улирал | Эхний хагас жилд | | **Жилийн эцэст** | |
| | | | | Төл. | Гүй. | **Төл.** | **Гүй.** |
| 1. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.1.**<br>Бодлого шийдвэрийн хэрэгжилт<br>(нийт бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундажаар авна) | Хувь | 88.0<br>(дундажаар) | 80.0 <<br>(дундажаар) | 78.1 | 90.0 <<br>(дундажаар) | 82.4 |
| 2. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.2.**<br>Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт | Хувь | - | 50.0 | 50.0 | 100.0 | 90.0 |
| 3. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.3.**<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд дэмжлэг, тусламж хүртсэн албан хаагчид | Тоо | 106<br>(давхардсан тоогоор) | 10 < | 10 <<br>(давхардсан тоогоор) | 15 < | 32 <<br>(давхардсан тоогоор) |
| 4. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.4.**<br>Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт | Хувь | 100.0 | 50.0 | 50.0 | 100.0 | 90.0 |
| 5. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.5.**<br>Авлига, ашиг сонирхлын зөрчөөс урьдчилан сэргийлэх сургалтын | тоо | 1551<br>(давхардсан | 30 | 41<br>(ЭБАТ) | 96 | 82<br>(давхардсан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдалт (төлөөлөл хэрэгжүүлдэг ТӨХЭ, ТӨБЗГ-ын албан хаагч) | | тоогоор) | | | | тоогоор, ЭБАТ) |
| 6. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.6.** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (тухайн жилийн тайланг дараа оны 1-р сард тайлагнадаг) | хувь | 2018 он 87.5 | 2019 он 85.0< | 88.0 | 2019 он 85.0< | 88.0 |
| 7. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.7.** Авлигатай тэмцэх газраас тогтоосон авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнд хүлээлгэсэн хариуцлага | Тоо, чанар | Тогтоогд-сон тохиол-долгүй. | Хэрэг, зөрчил тогтоог-доогүй байна. | 1 | Хэрэг, зөрчил тогтоог-доогүй байна. | 1 |
| 8. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.8.** Ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан албан хаагчийн тоо | Тоо | 2 | Ёс зүйн зөрчил гараагүй байна. | байхгүй | Ёс зүйн зөрчил гараагүй байна. | байхгүй |
| 9. | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.9.** Ёс зүйн дүрмийн хэрэгжилт | хувь | 97.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 10 | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.10.** Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ | тоо | 75 албан хаагч - “Хан-галттай” | - | - | 31 албан хаагч “Бүрэн хангалттай” болон “Хангалт-тай” үнэлгээ авсан байна. | 31 “Хангалт-тай” үнэлгээ авсан байна. |
| 11 | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.11.** Шагнал, урамшуулал авсан албан хаагчийн тоо | тоо | 15 | ... | ... | 31 | 33 (дав-хардсан тоогоор) |
| 12 | **Үр дүнгийн үзүүлэлт № 3.2.1.12.** Хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт | Хувь | 88.0 (өмнөх 3 жилийн дундаж) | 90.0 < | 92.62 | 95.0 < | 89.3 |

Мэдээллийн эх сурвалж: ТӨБЗГ-ын ЗУХ

## НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ № 2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

**Гүйцэтгэлийн зорилт № 3.2.2.** Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх

| *№ 28 (70)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.1-р арга хэмжээ** Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.9 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамж, Стратегийн зорилт 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ХЭЗХ, ЗУХ | | | | |
| | *Суурь түвшин* | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, бүтэц өөрчлөгдсөн. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэрэглэгддэг журам, дүрмийг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлсэн байх. | | | | |

| | | |
|---|---|---|
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна;<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлсэн байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- Шинэчлэн батлах журмын төсөлд албан хаагчдаас санал авч тусган хууль зүйд нийцүүлэн боловсруулсан байна;<br>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ийг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна;<br>- Хэрэгжилтийн хувь – 90.0< хувь байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх журам, дүрмийг боловсруулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлсэн.<br>ТӨБЗГ-ын “Хуралдааны дэг”-ийг шинэчлэн боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 53 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж байна.<br>Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг ТӨБЗГ-ын чиг үүрэгт хамааралгүй болсонтой холбоотойгоор ТӨБЗГ-ын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан. Үүнтэй холбоотойгоор нэгжийн дарга нарын орлон ажиллах хуваарийг шинэчлэн боловсруулж, Газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Б/66 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэв.<br>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу албан хаагчид болон хэлтсийн хүрээнд санал асуулга явуулан нийт албан хаагчийн хурал хийж, санал нэгтэн Газрын даргын 2020 оны А/10, А/61 дугаар тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулсан бөгөөд уг зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан газрын даргын А/15 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.<br>Батлагдсан хуралдааны дэг, нэгжийн дарга нарын орлон ажиллах хуваарь, ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам зэргийг байгууллагын цахим хуудас болон дотоод сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийт болон албан хаагчид танилцуулан мэдээлсэн байна.<br>Мөн Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу ТӨБЗГ-ын 2020 оны А/47 дугаар тушаалаар Баримт бичиг нягтлан шалгах комиссыг байгуулж, уг комиссын дүрмийг, А/48 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивын дүрэм”-ийг тус тус боловсруулан баталж, мөрдүүлээд байна. Түүнчлэн архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, заавар, стандартыг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-ын даргын А/52 дугаар тушаалаар зохион байгуулалтын нэгжийн индекс, А/57 дугаар тушаалаар тус байгууллагад хэрэглэгдэх хэвлэмэл хуудасны нэр төрөл, тэдгээрийн индексийг тус тус боловсруулан баталж, мөрдүүлэв. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | Уг ажилд тусгайлан хөрөнгө зарцуулаагүй болно. |
| | *Хүрсэн түвшин* | ТӨБЗГ-ын бүтэц, орон тооны асуудал тайлант жилийн сүүлчээр дахин өөрчлөгдсөнтэй холбоотойгоор шалгуур үзүүлэлтэд дурдсан зарим журам, дүрмийг боловсруулж батлах асуудлыг хойшлуулсан.<br>Хэрэгжилтийн мэдээлэлд дурдсан журмуудыг дотоод зохион байгуулалтын хүрээнд Төрийн албаны тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн мөрдүүлсэн байна. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 90 хувь |

<table>
<tr><td>№ 29 (71)</td><td colspan="6">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</td></tr>
<tr><td rowspan="2">Арга хэмжээний нэр, дугаар</td><td colspan="6">Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.2-р арга хэмжээ<br>Шинээр батлагдах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын төсөл, санал боловсруулах</td></tr>
<tr><td>Төлөвлөлтийн үндэслэл:</td><td colspan="5">Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.9 дэх заалт, Стратегийн зорилт 2.4.5.</td></tr>
<tr><td rowspan="4">Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</td><td>Хэрэгжих хугацаа</td><td>Улирал</td><td>1-р улирал</td><td>2-р улирал</td><td>3-р улирал</td><td>4-р улирал</td></tr>
<tr><td>Шаардагдах хөрөнгө</td><td colspan="5">... мянган төгрөг</td></tr>
<tr><td>Хариуцах нэгж</td><td colspan="5">ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ</td></tr>
<tr><td>Суурь түвшин</td><td colspan="5">-</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | *Шалгуур үзүүлэлт* | Чанарын үзүүлэлт:<br>- ТӨБЗГ-ын эрхлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулах, санал өгөх;<br>- Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал өгсөн байдал. |
| | *Хүрэх түвшин* | **Эхний хагас жилд:**<br>- ТӨБЗГ-ын эрхлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулалтаар хангасан байх;<br>- Дүрэм, журмын төсөл боловсруулсан байна;<br>- Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал боловсруулан өгсөн байна. |
| | | **Жилийн эцэст:**<br>- ТӨБЗГ-ын эрхлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын төсөл боловсруулсан байна;<br>- Төсөл батлагдаж, мөрдөгдсөн байна;<br>- Бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал өгсөн байна. |
| Арга хэмжээний хэрэгжилт | *Хэрэгжилт* | Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах үүднээс зарим зохицуулалтыг тодорхой болгох асуудлаар тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар хуралдаанд хэлэлцүүлж батлуулан, мөрдүүлэв. Хэлэлцсэн асуудлаар дараах шийдвэр гарсан:<br><br>- “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тогтоол;<br>- “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоол;<br>- “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай” 51 дүгээр тогтоол.<br>Хууль санаачлагчид, төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий албан хаагчдаас санал авахаар ирүүлсэн зарим хууль тогтоомж, журам, дүрмийн төсөлд холбогдох санал, хариуг өгч ажиллав. Үүнд:<br>- Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын санаачлан боловсруулсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд;<br>- ЗГХЭГ-аас ирүүлсэн “Барилга хүлээн авах, дуусаагүй барилга шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд;<br>- БСШУСайдаас ирүүлсэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд;<br>- Сангийн яамнаас ирүүлсэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд;<br>- БОАЖСайдаас ирүүлсэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд;<br>- ЗТХСайдаас ирүүлсэн Засгийн газрын тогтоолын төсөлд. |
| | *Зарцуулсан хөрөнгө* | - |
| | *Хүрсэн түвшин* | Тухайн арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн болно. |
| *Төсвийн шууд захирагчийн үнэлгээ* | | 100 хувь |

| *№ 30 (72)* | *Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээний нэр, дугаар | **Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.2.3-р арга хэмжээ**<br>Хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, мэдүүлэг, нотлох баримт гаргах | | | | | |
| | *Төлөвлөлтийн уялдаа:* | Стратегийн зорилт 2.4.5. | | | | |
| Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | *Хэрэгжих хугацаа* | *Улирал* | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
| | *Шаардагдах хөрөнгө* | ... мянган төгрөг | | | | |
| | *Хариуцах нэгж* | ХЭЗХ, хэлтэс, алба | | | | |
| | *Суурь түвшин* | 2019 оны жилийн эцсийн байдлаар хууль шүүхийн байгууллагад нийт 31 хэрэг маргаан хянагдаж, 14 хэрэг буюу 45.0 хувь нь эцэслэн шийдвэрлэгдсэн. Шийдвэрлэгдсэн хэрэг маргааны 11 буюу 78.5 хувьд ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашгийг хангасан шийдвэр гарсан байна. | | | | |
| | *Шалгуур үзүүлэлт* | - Хууль, хяналтын байгууллагад хянагдаж буй хэрэг, маргааны төрөл, тоо;<br>- Хэрэг, маргааны бүртгэл хөтөлсөн эсэх;<br>- Хэрэг, маргааны шийдвэрлэлт, хувиар. | | | | |

<table>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="2">Хүрэх түвшин</td><td>Эхний хагас жилд:<br>- Хэрэг, маргааны бүртгэл хөтөлсөн байна;<br>- Хэрэг, маргааныг шийдвэрлүүлэхэд холбогдох албан хаагчдын уялдаа холбоог хангаж, хамтран ажилласан байна;<br>- Хэрэг, маргааны талаар судалж, санал боловсруулах, удирдлагад танилцуулж, шийдвэрлэх арга хэмжээ авсан байна;<br>- Хэрэг, маргааныг шийдвэрлүүлж, байгууллагын эрх ашгийг хамгаалсан байна;<br>- Хэрэг, маргаанд холбогдох хариу тайлбар болон бусад ажиллагааг хийсэн байна.</td></tr>
<tr><td>Жилийн эцэст:<br>- Хэрэг, маргааны бүртгэл хөтөлсөн байна;<br>- Хууль тогтоомжийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байна;<br>- Хэрэг, маргаанд холбогдох хариу тайлбар болон бусад ажиллагааг хийсэн байна.</td></tr>
<tr><td rowspan="3">Арга хэмжээний хэрэгжилт</td><td>Хэрэгжилт</td><td>2020 оны жилийн эцсийн байдлаар хууль шүүхийн байгууллагад нийт 24 хэрэг маргаан хянагдаж, 7 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн. Шийдвэрлэгдсэн хэрэг маргааны 5 буюу 71.4 хувьд ТӨБЗГ-ын хууль ёсны эрх ашгийг хангасан шийдвэр гарсан байна.</td></tr>
<tr><td>Зарцуулсан хөрөнгө</td><td></td></tr>
